



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2019 • XI • № 39

*"Шөв банк түр зуурын улстөрийн
дарамтаас ангид үед эдийн засаг
хамгийн сайн байдаг"*

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



Mongolbank.mn



@mongolbank_mn



www.mongolbank.mn




Mongolbankmn




МОНГОЛБАНК

ТӨВ БАНКНЫ ХАРАА ХУУЛИНДАА



АТ БУС БАЙДЛЫГ ҮНДСЭН ТУСГАСАН УЛС ОРНУУД





Төв банк хэмээх институцийн анхны суурь XVII зууны Европт тавигдсан гэж үздэг ч “мөнгөний бодлого хэрэгжүүлэгч хараат бус төв банк” гэдэг өнөөгийн ойлголт харьцангуй шинэ буюу сүүлийн 20 гаруй жилд л олон улсад нийтлэг жишиг болжээ. Өнөөдөр дэлхийн 100 гаруй оронд төв банкны мөнгөний бодлогыг улстөрийн болоод аливаа хөндлөнгийн нөлөөллөөс хараат бусаар хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Ингэснээр мөнгөний бодлогын үндсэн зорилт болох **үнийн тогтвортой байдал хангагдах, инфляци нам дор түвшинд тогтвортой хадгалагдаж** эдийн засгийн тогтвортой байдалд чухал хувь нэмэр оруулдаг нь олон судалгаагаар батлагдаж, амьдрал дээр ч харагджээ.

Гэвч сүүлийн жилүүдэд “Төв банк хараат бус байх нь зүйтэй” гэдэг үзэл олон улс оронд сорилттой тулгарч, хөгжсөн орнуудад ч төв банкны хараат бус байдал руу халдах үзэгдэл газар авч байна. Үүнд дэлхий даяар гүнзгийрч буй орлогын тэгш бус байдал, үүнтэй холбоотой дэлгэрч буй популизм; төв банкуудын мөнгөний бодлогын үр дүнтэй байдал; даяарчлал ба технологийн дэвшилтэй холбоотой дэлхийн эдийн засагт бий болсон шокууд зэрэг олон хүчин зүйл нөлөөлж буй. Олон зуун жилийн түүхийн явцад улс орнуудын бодлого боловсруулагчдын алдаа оноон дээр тулгуурлан бий болсон “хараат бус төв банк” энэхүү сорилтыг хэрхэн даван туулахаас улс орнуудын эдийн засгийн тогтвортой байдал, нийгмийн сайн сайхан байдал ихээхэн хамаарах болно. Иймд төв банк хараат бус байхын ач холбогдлыг дахин нэг шүүн хэлэлцэж, нийгмийн зөвшилцөлд хүрэх нь чухлаар тавигдах болов.



Дэлхийн анхны төв банк
гэгддэг Рикс банк (Швед)
1668 онд үндэслэгдсэн
бол орчин үеийн төв
банкны суурь загвар болох
Английн төв банк 1694 онд
үүсгэн байгуулагджээ.

Төв банкууд XX зууны
эхэнд "шилжилтийн"
гэж нэрлэгддэг үетэй
золгожээ (Bordo, 2007).
Мөнгөний зориулалтаар
ашиглагдаж байсан олон
төрлийн хэрэгслүүдийг
нэгтгэх, алтны стандартыг
мөрдөж мөнгөн тэмдэгтийн
ханшийг тогтвортой
байлгах, банкны хямралын
үед тогтвортой байдлыг
ханган эцсийн зээлдэгчийн
үүргийг гүйцэтгэх зэрэг
нь тухайн үеийн төв
банкуудын гол үүрэг
болоод байв.

Төв банкиг улстөрийн
нөлөөнөөс хараат бус
болгох хандлага 1990-ээд
оноос эрчимтэй өрнөж
эхэлжээ.

Германы төв банк
(Бундесбанк) харьцангуй
эрт буюу 1957 оноос
Засгийн газраас хараат
бус мөнгөний бодлого
хэрэгжүүлж, өндөр
инфляцитай тулгараагүй.

"Инфляци нам дор бөгөөд
тогтвортой байх нь
чухал бөгөөд үүний тулд
төв банк хөндлөнгийн
нөлөөнөөс хараат бус
мөнгөний бодлого
хэрэгжүүлэх ёстой" гэдэг
зарчим олон улс оронд
нийгмийн зөвшилцөл болж
тогтжээ.



ХАРААТ БУС ТӨВ БАНК Б

Төв банкуудын товч түүх:



Хараат бус, хувийн эзэмшлийн төв банкуудын үе: XVII зуун -XIX зууны эхэн үе

XVII, XVIII зууны сэргэн мандалт, аж үйлдвэрийн хувьсгалын нөлөөгөөр нийгэм эдийн засаг хурдтай шинэчлэгдэж, банк санхүүгийн системийн ач холбогдол, эдийн засагт гүйцэтгэх үүрэг эрс нэмэгдсэн тул Европын бусад орнуудад банк санхүүгийн систем эрчимтэй хөгжиж, одоогийн төв банкуудын суурь тавигджээ. Анхны төв банкууд өмчлөлийн хувьд хувийн эзэмшлийн банкууд байсан бөгөөд Засгийн газарт зээл олгох, төлбөр тооцоог гүйцэтгэх, үнэт цаас буюу мөнгөн дэвсгэрт гүйлгээнд гаргах зэрэг чиг үүргийг гүйцэтгэх нь нийтлэг байв. Мөн банкны хямрал түгээмэл байсан учраас эцсийн зээлдэгчийн үүргийг гүйцэтгэх замаар банкинд итгэх итгэлийг хадгалах, эдийн засаг тогтвортой байлгах үүрэг функц нь хөгжиж эхэлсэн байна.



Засгийн газраас хараат, улсын өмчит төв банкуудын үе: 1930-аад он 1990 он

Дэлхийн I дайны дараагаас ялангуяа, 1930-аад оны Их хямралын дараа ажил эрхлэлтийн түвшин, эдийн засгийн идэвхжил болон үнийн түвшний тогтвортой байдал зэрэг макро эдийн засгийн асуудлууд чухал болсон байна. Энэ үеэс мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, мөнгөний нийлүүлэлтийг удирдах, үнэ ханшийн бодлого хэрэгжүүлэх, банк, санхүүгийн тогтвортой байдал болон макро эдийн засгийн тогтвортой байдлын асуудлуудыг төрөөс зохицуулах нь зүйтэй гэдэг үзэл дэлгэрэх болов. Улмаар төв банкуудыг нийгэмчилж, төрийн мэдлийн институци болгох үйл явц улс орнуудад өрнөсөн байна.

**I: ХАРААТ БУС,
ХУВИЙН ЭЗЭМШЛИЙН
ТӨВ БАНКУУД**



**II: ЗАСГИЙН ГАЗРААС
ХАРААТ, УЛСЫН
ӨМЧИТ ТӨВ БАНКУУД**

**III: ТӨВ БАНКУУД ХАРААТ
БУС, БИЕ ДААСАН ТӨРИЙН
ИНСТИТУЦИ БОЛЖ
ХӨГЖСӨН**

ИЙ БОЛСОН НЬ



**Төв банкууд хараат бус, бие даасан
төрийн институци болж хөгжсөн үе:
1990-одоо**

Инфляци нам дор бөгөөд тогтвортой байх нь чухал бөгөөд үүний тулд төв банк хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус мөнгөний бодлого хэрэгжүүлэх ёстой гэдэг зарчим олон улс оронд нийгмийн зөвшилцөл болж тогтжээ. Улмаар хараат бус төв банкны ач холбогдол, эдийн засагт үзүүлэх нөлөөний талаарх онолын үндэслэлүүд боловсруулагдахын зэрэгцээ зарим амжилттай улс орнуудын бодит туршлага бодлого боловсруулагч нарын анхаарлыг татах болсон байна. Төв банк хараат бус байх ёстой гэдэг энэхүү үзэл хүчээ авснаар 2010 он гэхэд дэлхийн 120 орчим улс орнууд ямар нэгэн байдлаар хуулиндаа төв банкны хараат бус байдлыг тусгаж өгчээ.



**Сорилтын үе:
2008- одоо**

1990-ээд оноос хойш хөгжсөн болон хөгжиж буй орнуудад инфляцийн түвшин буурч, хэлбэлзэл нь тогтворжиход хараат бус төв банк, инфляцийг онилох мөнгөний бодлогын үүрэг, нөлөө их байсан тул “төв банк хараат бус байх нь зүйтэй” гэдэг зөвшилцөл олон улсад нийтлэг жишиг болж тогтсон юм. Гэвч 2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш энэ үзэл баримтлалд сорилт тулгарч, нийгэм олон нийтийн зүгээс ч, улстөрчдийн зүгээс шүүмжлэх, няцаах оролдлогууд ихсэх хандлагатай болов. Иймд төв банкны хараат бус байдлын эдийн засагт бий болгох үр өгөөжийг дахин нэг нягталж, хараат бус төв банкны үнэ цэнийг эргэн нэг харж, нийгмийн зөвшилцөлд хүрэх шаардлага олон улс оронд тулгарч байна.



“ТӨВ БАНК ТҮР ЗУУРЫН УЛСТӨРИЙН ДАРАМТААС АНГИД ҮЕД ЭДИЙН ЗАСАГ ХАМГИЙН САЙН БАЙДАГ”

Энэ үгийг 1979-2018 оны хооронд 40 жилийн турш Америкийн мөнгөний бодлогыг жолоодсон төв банкны дөрвөн экс ерөнхийлөгч нээлттэй захидал бичжээ. Тэд чухам юу хэлэхийг хүсч тэрхүү нээлттэй захидлыг дэлхийн анхааралд хүргэсэн тухай уншигч танд толилуулж байна.

Зүүн гар талаас: Холбооны нөөцийн сангийн тэргүүн асан П.Волкер (1979-1987), А. Грийнспан (1987-2006), Б.Бернанке (2006-2014), Ж.Йеллен (2014-2018)

ИЛ ЗАХИДАЛ

Төв банк болон түүний тэргүүн эдийн засгийн сайн сайхан байдлын төлөө хараат бусаар ажлаа хийн түр зуурын улстөрийн дарамтаас ангид байх, ялангуяа улстөрийн зорилгоор Төв банкны тэргүүнийг огцруулах заналхийллээс ангид байх ёстойг тайлбарлахын тулд Холбооны нөөцийн системийн захирлуудын зөвлөлийг удирдаж байсан бид ийнхүү нэгдээд байна.

Бид дөрөв нийлээд 40 орчим жил улсдаа зүтгэсэн бөгөөд, Ардчилсан нам болон Бүгд найрамдах намын аль алинаас гаралтай Америкийн

6 Ерөнхийлөгч (Ж.Картер, Р.Рэган, Ж.В.Буш, Б.Клинтон, Ж.Буш, Б.Обама) биднийг томилж, зарим тохиолдолд бүрэн эрхийн хугацааг сунгаж байв. Бидний хэн хэн нь хуулиар заасан Холбооны нөөцийн сангийн зорилго болох “бүрэн ажил эрхлэлт” болон “үнийн тогтвортой байдал”-ыг хангахад эдийн засгаа чиглүүлэхийн тулд хүнд шийдвэрүүдийг гаргаж байсан. Эргээд харахад, бидний шийдвэр болгон төгс байгаагүй. **Гэхдээ шийдвэрүүд түр зуурын улстөрийн ашиг сонирхол бус, харин америк иргэдийн эдийн засгийн урт хугацааны тусын тулд нам бус, улстөрийн бус**

үнэлэмжид тулгуурлаж гарч байснаараа сайн байж чадсан гэдэгт бид итгэдэг.

Холбооны нөөцийн сангийн нам бус статус нь огт хяналтгүй, эгэх хариуцлагагүй (accountability) гэсэн үг биш. Конгрессээс төв банкны эрх мэдлийг тодорхойлж өгдөг бөгөөд бүрэн ажил эрхлэлтийг бий болгох, үнийн тогтвортой байдлыг хадгалахыг даалгадаг. Төв банкны тэргүүн болон Холбооны нөөцийн системийн бусад удирдлагууд Конгрессийн өмнө нээлттэй сонсгол хийхийн зэрэгцээ олон нийтэд хандсан яриа илтгэлээр дамжуулж эдийн засгийн байдлын талаарх үнэлэлт дүгнэлтээ,

хуулиар ногдсон үндсэн үүргээ хэрхэн биелүүлэх төлөвлөгөөгөө тогтмол тайлбарладаг. Америкийн Ерөнхийлөгч, Конгрессийн гишүүд, санхүүгийн зах зээлийн оролцогчид, эрдэмтэд болон хувийн хэвшил жирийн иргэд ч Төв банкныг тодорхой ямар нэг бодлогын шийдвэр гаргахыг зааж зөвлөж л байдаг. Энэ нь манай улсын засаглалын тогтолцоонд хүн бүрт байх ёстой эрх тул бид үүний эсрэг байдаггүй. Холбооны нөөцийн сан нээлттэй хэлэлцүүлгийг дуртай хүлээж авдгийг харуулах нэг жишээ бол “Fed listens” буюу “Төв банк сонсож байна” хөтөлбөр бөгөөд үүний хүрээнд Төв банкны удирдлагууд олон нийттэй харилцаж, бодлогын арга хэлбэрт орж магадгүй зарим өөрчлөлтийн талаар тайлбарладаг. Олон нийтийн идэвхтэй хэлэлцүүлэг мөнгөний бодлогыг илүү сайн болгоход ч тусалдаг.

Төв банк улстөрийн дарамтаас ангид, зөвхөн эдийн засгийн хатуу зарчим болон тоон мэдээлэлд үндэслэн үйл ажиллагаагаа явуулах үед эдийн засаг хүчтэй байж, хамгийн сайнаараа ажиллагдийг манай орны ч тэр, гадаад улс орны ч тэр түүх ахин дахин харуулсан билээ. Сонгуулийн үеэр улстөрийн лидерүүд төв банкнаас эдийн засгийг богино хугацаанд дэмжих мөнгөний бодлого явуулахыг шаардсан жишээ маш олон бий. Харин судалгаа юу гэж харуулдаг вэ гэхээр мөнгөний бодлого тухай үеийн улстөрийн хүсэл шаардлагад тулгуурлахаар алс хэтдээ эдийн засгийн муу гүйцэтгэлийг бий болгож, өндөр инфляци болон эдийн засгийн тааруу өсөлтөд хүргэдэг. Тэр ч бүү хэл мөнгөний

бодлогын шийдвэрүүд “улс төрийн ашиг сонирхлын нөлөөнд байна”, эсвэл “бодлого боловсруулагчдыг хугацаанаас нь өмнө огцруулна гэдэг заналхийллийн нөлөөнд байна” хэмээн ойлгогдох нь “төв банк эдийн засагт хамгийн тустай зүйлийг хийнэ” гэсэн олон нийтийн итгэлийг бууруулдаг. Энэ нь санхүүгийн зах зээл дээрх тогтворгүй байдал, эдийн засгийн таагүй үр дүнд хүргэх эрсдэлтэй.


Нам бус, хараат бус мөнгөний бодлого маш чухал байдаг учраас Конгресс ухаалгаар шийдэж Холбооны нөөцийн санг хараат бус агент болгосон бөгөөд бүс нутгуудын төлөөллийг хангаж, улстөрийн манипуляциас хамгаалж өгсөн. Тэдгээр хамгаалалтын нэг нь Холбооны нөөцийн сангийн захирлуудын зөвлөлийн гишүүдийн 14 жилийн бүрэн эрхийн хугацаа (тэргүүн болон дэд тэргүүн нар 4 жил) юм. Мөн Холбооны нөөцийн системийн салбар банкны захирлууд болон Холбооны нөөцийн сангийн тэргүүн, дэд тэргүүнийг улстөрийн лидерүүдтэй бодлогын талаарх зөрүүтэй байр сууринаас болж бус, зөвхөн хууль зөрчсөн эсвэл төстэй зүй бус үйлдэл гаргасан тохиолдолд л ажлаас нь чөлөөлөх боломжтой явдал юм. Бүрэн эрхийн хугацааг ийнхүү хатуу тогтоосон нь Төв банкны шийдвэр түр зуурын улстөрийн нөлөөллөөс ангид байж, эдийн засаг болон Та бидний тусын тулд байлгахын тулд билээ.

Сонгууль бүр үр дагавартай байдаг. Энэ нь Холбооны нөөцийн сан болон Засгийн газрын бусад агентуудад ч хамаарна. Одоогийн Төв банкны тэргүүний 4 жилийн

бүрэн эрхийн хугацаа дуусахад Америкийн Ерөнхийлөгч түүнийг дахин томилох, эсвэл шинэ хүнийг нэр дэвшүүлэх боломжтой. **Нэр дэвшүүлсэн хүнийг Сенат батлах ёстой. Тэрхүү шийдвэрийг гаргах үед нэр дэвшигчийг улс төрийн холбоо сүлбээ, үйл ажиллагаа бус харин ур чадвар, үнэнч шударга байдлыг нь харж сонгоосой гэж бид найдаж байна.** Холбооны нөөцийн сан хэсэг бүлэг улстөрчдийн төлөө бус, харин энэ улсын эрх ашгийн төлөө шийдвэр гаргах чадвартай байдлыг хамгаалах нь онцгой чухал юм.

*Эх сурвалж: Wall Street Journal
2019.08.05*

Төв банкууд төрийн институци болж, Засгийн газрын харъяанд үйл ажиллагаа явуулж эхэлснээр олон улс оронд өндөр инфляци асуудал үүсгэх болжээ. Тухайлбал, Британид инфляци 1960-аад оны сүүлийн хагасаас өсч 1970-аад онд 20% давж байсан бол АНУ-д инфляцийн түвшин 1970-79 хооронд 3%-аас 12% хүрч нэмэгдэхийн зэрэгцээ инфляцийн ирээдүйн хүлээлт тогтворгүй болоод байв. Энэ үед ажилгүйдлийн түвшин өндөр, эдийн засгийн өсөлт маш бага байсан нь нийгэмд сөрөг үр дагаврыг бий болгож байлаа. Төв банкууд Засгийн газрын харъяанд байх үед // улстөрчдийн нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлтийг хэт ихэсгэснээр стагфляци (өндөр инфляци, нам өсөлт) гэдэг үзэгдэлтэй нүүр тулахаас гадна мөнгөн тэмдэгтийн хямрал, эдийн засгийн хямралтай тулгарсан тохиолдол Латин Америкийн хөгжиж буй орнууд дунд ч цөөнгүй байв. Ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилгоор нийлүүлсэн мөнгө инфляцийг өдөөж, эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэснээр Төв банкны үүрэг ролийн талаар дахин авч үзэх шаардлага тулгарчээ.



ХОЛБООНЫ НӨӨЦИЙН БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДАЛ

Жером Повелл нь Холбооны нөөцийн банкны тэргүүний үүрэгт ажлыг хүлээж аваад даруй 2 жилийн нүүрийг үзэж байна. Тэрбээр дэлхийн хамгийн нөлөө бүхий төв банкыг удирддагийн хувьд маш их үүрэг хариуцлагыг хүлээдэг. Түүний хэлсэн үг бүр санхүүгийн зах зээлийг хөдөлгөх хүчтэй учраас ихээхэн болгоомжтой ажилладаг буй заа. Гэхдээ түүнээс үл хамаарч, түүнд ихээхэн дарамт үзүүлэх болсон нэг зүйл нь улс төрөөс нөлөөлөх гэсэн оролдлого юм. Женет Йеллений үүрэгт хугацаа дуусч Холбооны нөөцийн банкны тэргүүнийг сонгох шаардлага тулгарах үед Доналд Трамп анх Жером Повеллын нэрийг Сенатад оруулж батлуулсан хэдий ч одоо яагаад түүний бодлогыг шүүмжлэх болов? Энэхүү нийтлэлээр түүний учгийг тайлах болно.

Төв банкны тогтвортой байдал

АНУ-ын төв банкыг өнгөрсөн 40 жилийн хугацаанд 5 хүн удирдаж иржээ. Тэдний нэрийг дурдвал Пол Волкер (1979-1987), Алан Грийнспан (1987-2006), Бен Бернанке (2006-2014), Жанет Йеллен (2014-2018), Жером Повелл (2018-өнөөг хүртэл) нар аж. Хэрэв үүнийг ажиглавал Төв банкны тэргүүнийг 4 жилийн хугацаатай томилдогийг тооцоод гаргах боломжтой. Гэхдээ 4 жилийн хугацаа дуусах үед сунгах боломжтой ба Пол волкер 1 удаа, Алан Гриймспан 5 удаа, Бен

Бернанке 2 удаа дахин томилогдсон байдаг. Холбооны нөөцийн банк нь эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангахын төлөө ажилладгийн хувьд өөрийн үйл ажиллагаанд ч үүнийг хэвшүүлжээ. Өөрөөр хэлбэл удирдлагын тогтвортой байдал хангаж байна гэсэн үг.

Жером Повеллоос өмнө Төв банкыг удирдсан 4 эрхмийн өгсөн ярилцлагад “Бид дөрөв нийлээд 40 орчим жил улсдаа зүтгэсэн бөгөөд, Ардчилсан нам болон Бүгд найрамдах намын аль алинаас гаралтай Америкийн 6 Ерөнхийлөгч (Ж.Картер, Р.Эган, Ж.В.Буш, Б.Клинтон, Ж.Буш, Б.Обама) биднийг томилж, зарим тохиолдолд бүрэн эрхийн хугацааг сунгаж байв. Бидний хэн хэн нь хуулиар заасан Холбооны нөөцийн сангийн зорилго болох “бүрэн ажил эрхлэлт” болон “үнийн тогтвортой байдал”-ыг хангахад эдийн засгаа чиглүүлэхийн тулд хүнд шийдвэрүүдийг гаргаж байсан. Эргээд харахад, бидний шийдвэр болгон төгс байгаагүй. Гэхдээ шийдвэрүүд түр зуурын улс төрийн ашиг сонирхол бус, харин америк иргэдийн эдийн засгийн урт хугацааны тусын тулд нам бус, улс төрийн бус үнэлэмжид тулгуурлаж гарч байснаараа сайн байж чадсан гэдэгт бид итгэдэг” гэжээ.

Төв банк болон түүний тэргүүн тогтвортой ажиллаж, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад түр зуурын

улс төрийн дарамтаас ангид, хараат бус байх шаардлага тулгардаг. Урьд өмнө Төв банкыг Засгийн газраас хараат бус байхын талаар голлон ярьдаг байсан бол өдгөө үүнтэй ижил түвшинд улс төрийн хараат бус байдлыг онцлох болжээ. Засгийн газраас хараат бус байна гэдэг нь Төв банк төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийн тулд мөнгө хэвлэхгүй байх, эсвэл богино хугацааны өсөлтийг бий болгохын тулд мөнгөний бодлогыг хэт зөөлрүүлж, дайчлахгүй байх тухай юм. Дэлхийн Нэгдүгээр дайны дараахан Герман улс дайны өрөө санхүүжүүлэхийн тулд мөнгө хэвлэж байсан нь гипер инфляци үүсгэж, 50 тэрбум дойч марк хэвлэхэд хүргэж байсан бол саяхан Венесуэлийн хувьд Төв банк нь Засгийн газартайгаа хэт ойр ажилласан нь мөнгөн тэмдэгтийн хямралд хүргэх нэг шалтгаан болсон.

Доналд Трамп ба Жером Повелл

Оршил хэсэгт дурдсанчлан Доналд Трамп нь твиттерээр Жером Повеллийг байнга хурцаар шүүмжилдэг. Гэхдээ энэхүү шүүмжлэл нь голлон Холбооны нөөцийн банкны бодлого руу чиглэх аж. АНУ-ын Ерөнхийлөгч Төв банкны тэргүүнээ элдвээр хэлж байхад хэвлэлүүд, сенатын гишүүд маш хүчтэй хамгаалж байгаа нь ажиглагдана. Учир нь Доналд Трампаас өмнөх Ерөнхийлөгч нар нь Төв банкны хараат бус байдлыг ихэд эрхэмлэдэг байсан бол энэхүү уламжлалыг тэрбээр эвдэж байна.

Тэгвэл Трамп яагаад Повелийг шүүмжлэх болов? Үүнийг тайлбарлахын тулд БНХАУ болон АНУ-ын хооронд үүсээд байгаа худалдааны дайныг ойлгох хэрэгтэй. Ерөнхий утгаар бол АНУ нь БНХАУ-тай хийж байгаа худалдаанд ихээхэн алдагдалтай байгаа, цаашлаад оюуны өмчийн гэх мэт асуудлууд үүссэн учраас нийт 550 тэрбум ам.долларын бүтээгдэхүүнд АНУ тарифф ногдуулаад байгаа. Худалдааны дайн эд хурцдаж байх үед Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ өсгөж ирсэн. Бодлогын хүү нэмэгдэх үед тухайн улсын Засгийн газрын бонд, үнэт цаас гэх мэт активуудын үнэ өсдөг бөгөөд үүнийг дагаад ам.долларын ханш нэмэгдэнэ. АНУ нь экспортлогч орны хувьд худалдааны давуу байдлыг бий болгохын тулд ам.долларын ханшийг бусад валютуудын эсрэг сулруулахыг хүсдэг. Учир нь тухайн валют хямд байна гэдэг тэр улсаас экспортолж байгаа бүтээгдэхүүний үнэ хямд байх нөхцөл болно. Хоёр улсын яг ижил бараа ханшнаас үүдэлтэйгээр өөр үнэтэй байж болох ба энэ үед хэрэглэгч аль хямдыг нь сонгоно.



Зураг. Холбооны нөөцийн банкны хүүгийн өөрчлөлт

Жером Повелл ирээдүйд үүсч болзошгүй эрсдэл, инфляцийн дарамтыг бууруулахын тулд бодлогын хүүгээ өсгөж байсан нь Трампын худалдааны бодлоготой авцалдахгүй байж. Тиймээс Трамп бодлогын хүүгээ бууруул гэж Жером Повелллийг шахаж байна. Хамгийн сүүлд 2019 оны 10-р сард Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ 0.25% бууруулж 1.50-1.75 хооронд тогтох шийдвэр гаргасан. Жером Повелл энэхүү шийдвэрийг танилцуулах хурлын үеэр ч тэр, Конгресст хийсэн сонсголын үеэр ч тэр бодлогын хүүг ойрын хугацаанд бууруулах төлөвлөгөө байхгүй гэж мэдэгдсэн. Гэтэл Трампын зүгээс твиттерээр элдэв үг чулуудаж, Төв банкыг удирдаж чадах эсэх дээр эргэлзэж байгаагаа хэлэв. Мөн цаашлаад бодлогын хүү хэт өндөр байгаа хүүг харин ч хэт зөөлөн буюу хасах түвшинд хүргэх хэрэгтэй гэжээ.

Энэ бүхний ард хоёр хүний хоорондын харилцаа бус улс орны Төв банкинд итгэх итгэл оршиж байгаа. Хэдийгээр АНУ-д эдийн засгийн бүтэц маш тодорхой болж, хөгжиж чадсан ч Төв банкны хараат бус байдал дэнсэн дээр нь байгаа аж. Ерөнхийлөгчийн сонгууль 2020 оны 11 сард болох гэж байгаа энэ үед Трампын эдийн засгийн бодлогод өгөх дүгнэлт ихээхэн холимог байгаа. Хэрэв худалдааны маргаанд Трамп давуу тал олж Төв банкыг өөрийн үгэнд оруулж чадвал богино хугацаанд ихээхэн өсөлтийг бий болгож сонгуульд ялж болох ч, урт хугацаанд хэр тогтвортой байх вэ гэдэг дээр асуудлыг гол учиг байгаа юм.

Эх сурвалж: <https://www.washingtonpost.com/business/2019/11/13/fed-chair-believes-economy-will-keep-growing-signals-plan-stand-pat-interest-rates/>

<https://www.wsj.com/%E2%80%A6/america-needs-an-independent-fed-1156%E2%80%A6> <https://www.trends.mn/n/9061>



МОНГОЛ



Монгол Улс 1990 оноос чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоо руу шилжилт хийснээр 2 шатлалт банкны тогтолцоо үүсч хөгжин, санхүүгийн зах зээлийн хөгжил болон мөнгөний бодлогын чиг хандлагад чухал өөрчлөлт бий болсон билээ. Эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжсэнээр Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төв банк болон зохион байгуулагдаж, Төв банкны тухай хууль 1996 онд анх батлагдан, 2018 онд нэмэлт, өөрчлөлт орж шинэчлэгджээ. Энэ хугацаанд Төв банкны хараат бус байдалд сорилтууд тулгарсаар ирсэн бөгөөд цаашид Монголбанкны хараат бус байдлыг хэрхэн бэхжүүлэхээс мөнгөний бодлогын хэрэгжилт, макро эдийн засгийн тогтвортой байдал хамаарна. Харин энэ сэдвээр хийгдсэн судалгаа шинжилгээний ажил, дүгнэлт зөвлөмж маш цөөн байгаа нь бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэхэд төвөгтэй байдлыг үүсгэсээр иржээ.

СУДЛААЧДЫН СУДАЛГААНЫ АЖЛЫН ГОЛ ДҮГНЭЛТҮҮДЭЭС

ҮНДСЭН ХУУЛЬ БА ТӨВ БАНКНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

МУИС-ийн ХЗС-ийн профессор, **Д.ГАНГАБААТАР**

...Төв банкны эрх зүйн зохицуулалтын үндсийг ямар хуулиар олгох нь төв банкны үйл ажиллагаанд нөлөөтэй байдаг. Жишээ нь: Засгийн газрын шийдвэрээр зохицуулдаг бол тогтворгүй, байнга өөрчлөгдөх нөхцөл бүрдэнэ. Харин Үндсэн хуулиар зохицуулсан тохиолдолд эрх зүйн үндэс суурь нь бат тавигддаг. Улс төрийн болон бусад зохисгүй нөлөөнөөс төв банкныг хараат бус байлгахын тулд ердийн хуулиар бус, харин Үндсэн хуулиар эсхүл дийлэнх олонхийн саналаар өөрчлөгддөг органик хууль, мөн түүнчлэн олон улсын гэрээгээр баталгаажуулах шаардлагатай байдаг. Эдгээр дээд эрэмбийн хуулийг өөрчлөхөд тавигдах хатуу процессын шалгуур нь төв банкны эрх мэдэлд хөндлөнгөөс халдах зэрэг зохисгүй нөлөөллөөс хамгаалах учиртай...

...Үндсэн хуулиар банкны бүрэн эрхийг тодорхойлоод зогсохгүй хүлээх үүрэг хариуцлагыг ч хуульчилдаг. Хувьцаа эзэмшигч нь төв банкны бодлого, банкны санхүүжилт зэрэгт нөлөөлөх нөлөөг хязгаарлах, удирдах албан хаагчдын бусад санхүүгийн байгууллагад ажиллах, тодорхой үйл ажиллагаа эрхлэх боломжийг хязгаарлах, улс төрийн албан тушаалд өрсөлдөхийг хориглох зэрэг олон төрлийн хязгаарлалтууд байдаг...

...Эдгээрээс нэн чухал нэг хязгаарлалт бол **төв банк нь засгийн газраасаа хараат бус байх тухай юм. Төв банкны хараат бус байдлыг хангах зорилгоор засгийн газраас аливаа хэлбэрээр төв банканд чиглэл өгөхийг хориглодог.** Жишээ нь: Мексикийн Үндсэн хуульд аливаа албан тушаалтан, эрх мэдлийн байгууллага төв банканд санхүүжилт олгох чиглэл, тушаал өгөхийг хориглоно гэжээ. Европын төв банк нь засгийн газрууд, гишүүн улс, үндэсний төв банк зэрэг ямар ч байгууллагаас чиглэл, заавар авахгүй гэжээ. Мөн Засгийн газарт эзэл олгох, засгийн газрын үнэт цаасыг худалдан авахыг хязгаарлах зохицуулалт түгээмэл байна. Засгийн газрыг санхүүжүүлснээр

мөнгөний бодлогод харшлах нөхцөл үүсгэхгүйн тул энэхүү хязгаарлалтыг тавьдаг. Энэ хязгаарлалт нь бүрэн хязгаарлах, тоон хязгаарлалт, зорилгоор хязгаарлах зэргээр олон төрөлтэй байна...

... Зарим талаар эрх зүйн бүлийн онцлогоос хамаарч төв банкныг Үндсэн хуулиар зохицуулах асуудал улс орнуудын хувьд ялгаатай байна. Төв банкны зорилго, чиг үүрэг, бодлого боловсруулах, бодлогын шийдвэр гаргах, тэдгээр шийдвэрээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бие даасан байдлыг баталгаажуулахад Үндсэн хуулийн зохицуулалт чухал үүрэгтэй. Төв банкныг улс төрөөс хараат бус, чиг үүргээ хэрэгжүүлэх, тогтвортой байх эрх зүйн боломжийг Үндсэн хуулийн зохицуулалт олгодог. Төв банкныг Үндсэн хуулиар шууд зохицуулсан улс олон бий. Харин шууд бусаар зохицуулсан улс Монгол Улсыг оруулаад түүнээс ч олон байна. Шууд бус зохицуулалт нь Үндсэн хуулийн үзэл баримтлал, зарчим, тодорхой төрийн институцэд олгосон эрх мэдлийг хэрэгжүүлэхтэй холбоотой Үндсэн хуулийн тайлбараа илэрч байна...

БОДЛОГЫН ТУУШТАЙ БУС БАЙДАЛ БА ТӨВ БАНКНЫ БИЕ ДААСАН БАЙДАЛ

СЭЗИС-ийн багш, судлаач **Д.ТҮВШИНЖАРГАЛ**

... Тухайн улсын төв банкны бодит хараат бус байдлыг ихэнхдээ баталсан төв банкны хуулийн хүрээнд хэмждэг. Ингэхдээ хэд хэдэн судлаачдын боловсруулсан хуулийн хүрээнд хэмжих индексийг ашигладаг (Cukierman, 1992; Cukierman, Webb and Neyapti, 1992; Grill, Masciandaro and Tabellini, 1992; Eijffinger and Schaling, 1992, 1993a). Мөн хуулийн хүрээнд тооцохоос гадна бие даасан байдлыг төв банкны ерөнхийлөгчийн солигдолтын түвшин, иргэдээс санал асуулга авах зэргээр тодорхойлдог. Энэхүү судалгааны ажилд зөвхөн хуулийн хүрээнд бие даасан байдлыг тодорхойлохыг хичээсэн болно.

Төв банкны бие даасан байдал хуулийн хүрээнд ямар байгааг тодорхойлохдоо судлаачдын өргөн ашигладаг, нөгөө талаар бусад улсуудын үр дүнтэй харьцуулах үүднээс Кьюкермен, Вебб, Ньюапти нарын

1992 онд боловсруулсан LVAV индексийг ашигласан болно(Cukierman, Webb and Neyapti, 1992). Энэ индекс нь төв банкны бие даасан байдлыг хуулийн хүрээнд дараах дөрвөн талбарт тооцдог. Үүнд:

- 1) Төв банкны ерөнхийлөгчийг сонгох процетур, Төв банкны ерөнхийлөгчийг томилох, хугацаа, огцруулах
- 2) Мөнгөний бодлого тодорхойлох, Мөнгөний бодлого боловсруулахад төв банк болон засгийн газар хоорондох эрх үүргийн хуваарилалт, төсвийн процесс дахь төв банкны оролцоо
- 3) Төв банкны бодлогын зорилго, Төв банк үнийн тогтвортой байдлыг бодлогын зорилгоо болгож байгаа эсэх
- 4) Засгийн газарт олгох зээлийн хязгаарлалт, Төв банкнаас төрийн секторт олгох зээлийн хэмжээ, хүү, нөхцлийн хязгаарлалт...

... Монгол улсын Төв банк/Монголбанк/-ны 2010 он болон 2018 онд нэмэлт өөрчлөлт оруулсан 1996 оны хуульд тулгуурлан ТББДБ-ийг хуулийн хүрээнд LVAV индексээр тооцов. Уг судалгааг 2011 хийсэн бөгөөд тэр үеийн LVAV индексийн аргачлалаар Монгол улсын 2010 оны 1-р сарын 28-нд нэмэлт өөрчлөлт оруулсан Төв банк/Монголбанк/-ны 1996 оны хуульд тулгуурлан өөрийн зүгээс ТББДБ-ыг тооцоолоход 0.51 гэж гарсан юм. Энэ үр дүнг задлан шинжилвэл Төв банкны ерөнхийлөгчийг сонгох, ялангуяа засгийн газарт олгох зээлийн хязгаарлалтын талбарын утга бага байна.

№	Талбарууд	Боломжит дээд утга	Индексийн утга	
			2010	2018
1	Төв банкны ерөнхийлөгч сонгох	0.2	0.14	0.14
2	Мөнгөний бодлого тодорхойлох	0.15	0.11	0.11
3	Мөнгөний бодлогын зорилго	0.15	0.09	0.09
4	Засгийн газарт олгох зээлийн хязгаарлалт	0.5	0.16	0.22
5	НИЙТ	1	0.51	0.56

Харин 2018 оны нэмэлт өөрчлөлт орсон хуулийн хүрээнд тооцсон индексийн утга 0.56 болж 10 орчим хувиар нэмэгдсэн үр дүн гарсан...

...Монгол улсын хувьд хуулийн хүрээнд төв банк/Монголбанк/-ны бие даасан байдлыг индексээр хэмжсэн судалгааны үр дүнгээс дараах дүгнэлт өгөхийг хичээлээ.

- Төрийн инфляцийг бууруулах гэсэн дискрет бодлого

цаанаа нийгмийн баялагыг нэмэгдүүлэх зорилготой гэдгийг мэдэх рациональ эдийн засгийн агентууд инфляцийн хүлээлтээ багасгахгүй бөгөөд бодлогын итэлгүй байдал нь урт хугацаанд бодлогын тууштай бус байдлаас үүдэлтэй аядуу инфляцийг бий болгодог байна.

- Төв банкны баримтлах дискрет бодлого эдийн засгийн агентуудад итгэл төрүүлэхүйц байх интитуцийн дизайныг төв банкны бие даасан байдал гэж олон эдийн засагчид санал болгох болжээ. Мөн шинэ улс төрийн макроэкономикст ардчилсан сонгуультай орнуудад улс төрчид сонгогчдоос оноо авах гэж сонгуулийн өмнө эдийн засгийг тэлэх, инфляцийн гэнэтийн бэлэг барихыг санаархдаг тул улс төрчдийн энэ үйл хөдлөлийг хязгаарлах институц хэрэгтэй тэр нь хараат бус төв банк байж болохыг энэ чиглэлийн эдийн засагчид санал болгодог байна.
- Монгол улсын төв банк/Монголбанк/-ны 2010 онд нэмэлт өөрчлөлт орсон 1996 оны хуульд тулгуурлан манай улсын төв банкны бие даасан байдлыг LVAV индексээр тооцоход 0.51 гэсэн утга авсан бол 2018 оны нэмэлт өөрчлөлтөөр 0.56 болж 10 орчим хувиар өссөн байна. Тухайлбал, индекс тооцох дэд талбар дотроос өмнө нь хамгийн бага утга авч байсан засгийн газарт олгох зээлийн хязгаарлалт талбарт зохих ахиц гарсан. Тэр нь Төв банкны тухай хуулийн 18-р зүйлийн 1 дэх заалтыг 2018 оны хуулиар шинэчлэн найруулж засгийн газарт олгох зээлийн хязгаарлалтыг нарийн зааж өгсөн. Мөн түүнчлэн Монголбанкны үйл ажиллагаанд хориглох зүйлд хувь хүн, хуулийн этгээд, тухайлсан банк, салбарт эдийн засгийн давуу байдал олгохыг хориглосон.
- Төв банкны удирдлагын хувьд ч хараат бус байдал зохих хэмжээнд нэмэгдсэн байна. 2018 оны хуулийн өөрчлөлтөөр Төв банк Мөнгөний бодлогын хороотой байх ба долоон гишүүний дөрөв нь орон тооны бус гишүүнээс бүрдэж байна. Мөнгөний бодлогын хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр дүрэм зааж өгсөн. Гэхдээ Төв банкны хуулийн хүрээндэх хараат бус байдал тухайн улсын хуулийн засаглал (rule of law)-ын чанараас хамаарч мөнгөний бодлогын зорилго биелэхэд нөлөөлж байна. Тиймээс Монгол улсын засаглалын чанараа ахиулаагүй цагт уул

уурхайн мөчлөг дагаж Монголбанкны хараат бус байдал сорилттой тулгарсан хэвээр байна.

ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫГ ҮНДСЭН ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛАХ НЬ: ҮНДСЭН ХУУЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛЫН ХАНДЛАГА

Хуульч, судлаач **Ж.САЙНХИШИГ**

...Сүүлийн жилүүдэд Монголбанк Засгийн газартай хамтарсан "Үнэ тогтворжуулах хөтөлбөр", эдийн засгийн тодорхой салбарт чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэр банкинд олгох арга хэмжээ, зах зээлийн бус зарчмаар валютын ханшийн зөрүүний хөнгөлөлт үзүүлж тогтоосон санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцэл болон хуулийн зохицуулалтаас гадуур хийгдсэн зарим хэлцэл нь зах зээлийн хүүгээс хөнгөлөлттэй хүү тооцох, ханшийн зөрүүг банк, хуулийн этгээдэд олгох замаар хийгдсэн төсвийн шинж чанартай үйл ажиллагаа болсон нь төв банкны бүтэц, хараат бус байдлын эрх зүйн баталгааны талаар нухацтай авч үзэхийг шаардлагатайг харуулж байна.

Монголбанкны удирдлага сонгуулийн мөчлөгтэй давхцаж, солигддог, Улсын Их Хурал болон Засгийн газраас мөнгөний бодлогыг хэрэгжилтийг алдагдуулах арга хэмжээ, хөтөлбөрийг Монголбанкинд үүрэг, зөвлөмж байдлаар өгч, хэрэгжүүлж байгаагаас нийгэм, эдийн засагт төв банк үнийн тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүргээ хангалттай гүйцэтгэж чадахгүй байна гэсэн шүүмжлэл дагуулж байна.

Мөнгөний бодлого, төв банкны удирдлагын томилгоог улс төрийн институци шийдвэрлэж байна. Улс төрийн шийдвэр гаргалтын үндсэн баримт бичиг нь Үндсэн хууль болохын хувьд төрийн эрх мэдлийг ард түмний эрх ашигт нийцүүлэн дүрэмлэж өгөөгүйгээс ашиг хонжоо хайх сэдэл, сонгуулийн амлалт зэрэг хүчин зүйлийн улмаас төрийн шийдвэрт явцуу эрх ашиг нөлөөлөх үзэгдэл манай улсыг мөн тойрсонгүй.

Дээрх асуудлын шалтгааныг төв банкны үндсэн чиг үүргийг зөв тодорхойлоогүй, хараат бус байдлын баталгаа хангагдаагүйн улмаас тус институцид улс төрийн нөлөөлөл орж байгаатай холбоотой гэж үзэж байна...

ТӨВ БАНКНЫ БИЕ ДААСАН БАЙДАЛ, ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ: ДЭЛХИЙН ДАХИНД

БЕРНАРД,
АРНОН-ОУВС, 2009

Үр дүн: Бие даасан төв банк нь инфляцийг дор түвшинд барьж, улс төрийн шийдвэрээр эдийн засгийн мөчлөг үүсэхэд зөөлөвч болохоос гадна гарцын хэлбэлзэл болон эдийн засгийн хөгжлийг бууруулах талаасаа илүү зардал, төлөөс гаргалгүйгээр төсвийн сахилга батыг сайжруулах замаар макро эдийн засгийн үзүүлэлтэд онцгой үр өгөөж өгдөг байна.

ТӨВ БАНКНЫ УЛС ТӨРИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫН ИНДЕКС –LVAV-LVAW"

ALEX CUKIERMAN НАР (1992)

Тавигдсан асуулга: Төв банкны удирдлага (бүрэн эрхий хугацаа, томилгоо, албан тушаалаас чөлөөлөх үндэслэл), Бодлого боловсруулалт (Мөнгөний бодлогыг боловсруулах этгээд, мөнгөний бодлогын талаар зөрөлдөөн гарсан тохиолдол шийдвэрлэх арга зам, төсвийг боловсруулахад төв банкны оролцоо), Төв банкны зорилт (Үндсэн зорилтын томьёолол), Засгийн газарт санхүүжилт олгох хязгаарлалт (санхүүжүүлэх хязгаар, үнэт цаасны хэлбэрээр зээл олгох хязгаар, зээлийн нөхцлийг тогтоох этгээд) гэсэн үзүүлэлт.

Үр дүн: Төв банкны удирдлага (бүрэн эрхий хугацаа, томилгоо, албан тушаалаас чөлөөлөх үндэслэл), Бодлого боловсруулалт (Мөнгөний бодлогыг боловсруулах этгээд, мөнгөний бодлогын талаар зөрөлдөөн гарсан тохиолдол шийдвэрлэх арга зам, төсвийг боловсруулахад төв банкны оролцоо), Төв банкны зорилт (Үндсэн зорилтын томьёолол), Засгийн газарт санхүүжилт олгох хязгаарлалт (санхүүжүүлэх хязгаар, үнэт цаасны хэлбэрээр зээл олгох хязгаар, зээлийн нөхцлийг тогтоох этгээд) гэсэн үзүүлэлтийг авч үзэн 0-1 хүртэл оноогоор үнэлж "Хөгжингүй улсуудын хувьд төв банкны хуульд түүний бие даасан байдал хангагдсан тохиолдолд инфляцийн түвшин буурдаг"

...Мөнгөний тогтолцоог үндсэн хуульчлах хандлага нь Үндсэн хуулийн эдийн засгийн онолоос тодорхой хэмжээнд тусдаа хөгжсөн ч энэ онолын нэг хэрэглээний чиглэлд хамаарахаар байна. Үндсэн хуулийн эдийн засгийн онол нь хууль тогтоомжоор зорилтыг нь тодорхой зохицуулсан, парламент, гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус төв банк нь мөнгөний бодлогыг урт хугацааны нийтийн ашиг сонирхлын төлөө бус богино хугацааны улс төрийн ашиг сонирхолд чиглэгдэхээс сэргийлж чадна гэж үздэг байна...

...Манай улстай адил нийгэм эдийн засгийн шилжилт хийж буй, мөн Европын холбоонд нэгдэн орох шаардлагыг хангаж буй пост социалист улсуудын үндсэн хуульд төв банкны хараат бус байдлыг Үндсэн хуулиар дэлгэрэнгүй зохицуулах хандлагатай байна.

Харин хөгжингүй орнуудын Үндсэн хуульд тухайн улсын төв банкны статус, удирдлагын томилгооны асуудал зэрэг харьцангуй товч зохицуулалт байна. Тухайлбал, ХБНГУ, Финланд, Норвег, Швейцар, Швед зэрэг улсууд энэ ангилалд багтахар байна.

Дэлхийн улсуудын төв банкны талаарх үндсэн хуулийн зохицуулалтад төв банкны статус, бүтэц, хараат бус байдал, органик хуулиар бусад харилцааг зохицуулах асуудал, мөн төв банкны зорилго, мөнгөний бодлогын зорилт, засгийн газарт зээл олгохыг хориглох, удирдлагыг томилох, чөлөөлөх, ажлаа тайлагнах субъект зэрэг харилцааг хамарч байна...

... Олон улсын валютын сангийн 2016 оны судалгаагаар 154 улсаас 127 улсад төв банк нь үнийн тогтвортой байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлж байгаагаас харахад уг зорилтыг төв банкны үндсэн зорилт гэж үзэхээр байна. Энэ нь дотроо (1) үнийн тогтвортой байдлыг хангах зорилт дангаараа (2) эсхүл уг зорилт дээр нэмээд бусад дагалдах зорилттой, (3) мөн үнийн тогтвортой зорилт нь төв банкны бусад макро зорилттой нэг адил зорилт гэсэн гурван хэлбэртэй байна. Төв банкны үндсэн зорилт нь үнийн тогтвортой байдлыг хангах бөгөөд бусад дагалдах зорилттой байх хэлбэр хамгийн түгээмэл байна...

ТӨВ БАНКНЫ БИЕ ДААСАН БАЙДЛЫН ИНДЕКС–СВІG

AMIRU AHSAN, MICHAEL SKULLY БА
J.WICKRAMANAYAKE НАР

Тавигдсан асуулга: Төв банкны удирдлагын эрх зүйн зохицуулалт, Улс төрийн нөлөөлөл, Үнийн тогтвортой байдлын зорилт, Валюын бодлого, Мөнгөний бодлого ба засгийн газрын алдагдлыг санхүүжүүлэх; Хариуцлага ил тод байдал

Үр дүн: Төв банкны удирдлагын эрх зүйн зохицуулалт (бүрэн эрхийн хугацаа, томилох чөлөөлөх эрх мэдэл); Улс төрийн нөлөөлөл (удирдлагын солигдолт, төв банкны удирдах хорооны гишүүд, төв банкны удирдлага Засгийн газарт албан тушаал давхар хаших байдал); Үнийн тогтвортой байдлын зорилт (Үнийн тогтвортой байдал, инфляци, хүүгийн түвшин); Валюын бодлого (интервенц, гадаад валютын зах зээлийн зохицуулалт, гадаад валютын зээллэг); Мөнгөний бодлого ба засгийн газрын алдагдлыг санхүүжүүлэх (Мөнгөний бодлого боловсруулах чиг үүрэг, зөрчилдөөнийг шийдвэрлэх механизм, засгийн газарт зээл олгох, зээлийн нөхцөл, хугацаа, хүү); Хариуцлага ил тод байдал (Төв банкны зорилт, харилцааны стратеги, олон нийтэд үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, төв банкны удирдлагын хариуцлага, аудит) гэсэн үндсэн 6 төрлийн шалгуур үзүүлэлтээр 0-1 оноогоор хэмжиж, төв банк засгийн газраас хараат бус байх нөхцлийг тодорхойлсон байна.

ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ, ТҮҮНИЙ ИНФЛЯЦИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨНИЙ ЭКОНОМЕТРИК ЗАГВАР

Л.ЭНХ-ОРЧЛОН,
Б.ДҮЙНХЭРЖАВ НАР (2013)

Үр дүн: Монголбанкны хараат бус байдал харгалзан 86.6%, 73.6%, 70.5%-ийн хараат бус байдалтай гэсэн тооцоолол гарсан бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч бүрэн эрхийн хугацаанаас өмнө солигддог, Монголбанкны удирдлага улс төрөөс хараат байдал, Засгийн газрыг санхүүжүүлдэг гэсэн үзүүлэлт дээр дутагдалтай гэсэн дүгнэлт хийжээ.

... Манай улсын хувьд төв банк хуулиар үнийн тогтвортой байдлыг хангахаас гадна өөр чиг үүргийг гүйцэтгэж, мөн УИХ-аас тогтоол гаргах замаар тодорхой ажил үүргийг уг байгууллагад даалгаж байгаа нь төв банкны бие даасан байдлыг алдагдуулах нэг үндэслэл болж байна. Иймд олон улсын нийтлэг жишгийн дагуу үнийн тогтвортой байдлыг хангах нь төв банкны үндсэн зорилт гэдгийг тодорхойлж өгснөөр улс төрийн байгууллагаас тус институцид нөлөөлөх нөлөөллийг хязгаарлах боломжтой...

ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН: ТӨВ БАНК (МОНГОЛБАНК)-НЫ ТУХАЙ ХУУЛЬ

*Монголбанкны ЭБХХ-ийн захирал **Б.ЭРДЭНЭХУЯГ**,
Монголбанкны ЭБХХ-ийн
мэргэжилтэн **М.НИНЖБАДГАР***

...1991 оны Монгол Улсын банкны тухай хуулиас эхлэлтэй Монгол Улсын төв банкны эрх зүйн байдал, бие даасан, хараат бус байдлыг Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд тодорхой тусгасан боловч Монголбанкны үндсэн зорилтыг тодорхой болгож үйл ажиллагааны бие даасан байдлыг, төв банкны засаглал буюу удирдлагын томилох, чөлөөлөх шалгуур, журмын нарийвчлан тогтоож инстиуцийн бие даасан байдлыг, төв банкны санхүүгийн чадавхи, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж санхүүгийн хараат бус байдлыг тус тус хангах чиглэлээр хуулийн шинэчлэлийг өнөөгийн цаг үе, Монгол Улсын онцлогийг харгалзан олон улсын чиг хандлагад нийцүүлэн хийх шаардлага оршсоор байна.

Ингэхдээ тус хуульд дараах зохицуулалтыг тусгахад боломжтой гэж үзэж байна:

1. Монголбанкны үндсэн зорилтыг үнийн тогтвортой байдал болгон хуульчилж, мөнгөний бодлогын зорилтыг Улсын Их Хурлаас тодорхойлох болон мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх явцад түүнд сөргөөр нөлөөлөх аливаа шийдвэр гаргахыг хязгаарласан хамгаалалтыг хуульд тусгах,
2. Монголбанкны удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлыг “давхар хяналт”-ын зарчмаар буюу нэг бие даасан этгээд нэр дэвшүүлж, өөр этгээд шийдвэрлэдэг байх, удирдлагыг томилох, чөлөөлөх шалгуурыг нарийвчлан тусгах, Монголбанкны үйл ажиллагаанд хяналт тавих этгээдийг тодорхой болгож, аливаа зүй бус нөлөөллөөс ангид байх нөхцөл бүрдүүлэх эрх зүйн хамгаалалтыг хуульчлан

баталгаажуулах,

3. Монголбанкны санхүүгийн алдагдалыг Засгийн газраас үнэт цаас гаргаж нөхөх зохицуулалтыг хуульд тусгах...

ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДАЛ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, МОНГОЛБАНКНЫ АНХААРАХ АСУУДЛУУД


*Монголбанкны МБТХ-ийн
захирал **Н.УРГАМАЛСУВД**,
ЭЗШБХ-ийн захирал **Б.ТҮМЭНЦЭНГЭЛ**,
эдийн засагч **Б.ГАНЧИМЭГ***

...Монголбанкны үндсэн зорилтыг салаа утгаараа “валютын ханшийг тогтворжуулах” гэж ойлгогдохоор тодорхойлох нь бодитоор биелэх үндэслэлгүй тул Төв банкны нэр хүнд болон үйл ажиллагааны тогтвортой байдалд эрсдэл учруулж байна. Ханшийн дэглэмийн хувьд Монгол улс “удирдлагатай хөвөгч” тогтолцоотой улс юм. Хөрөнгийн чөлөөт урсгалтай тул төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь хүчин зүйлс /эдийн засгийн бүтэц, үйлдвэрлэх чадвар, гадаад худалдаа, гадаад өрийн хэмжээ, хөрөнгө оруулалтын таатай орчин гм/, үүнтэй уялдаад төлбөрийн тэнцэл /валютын орох гарах урсгал/-ээр шууд тодорхойлогддог. Төв банк ханшийн богино хугацааны огцом хэлбэлзлийг зөөлрүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэрэгслүүдээ /интервенци, бодлогын хүү г.м/ ашиглаж ирсэн. Ханшийн уян хатан байдал нь Монгол Улс шиг жижиг, нээлттэй эдийн засагтай оронд гадаад шокыг шингээх, гадаад, дотоод секторын тэнцвэрийг хангахад зохицуулагчийн үүрэг гүйцэтгэх ач холбогдолтой байдаг. Харин ханшийн тогтмол дэглэмийг хэрэгжүүлэхэд нэг зайлшгүй суурь тулгуур нь болдог хөрөнгийн хяналт /капитал контрол/ нь гадаад санхүүжилт эдийн засагт чухал ач холбогдолтой манай орны хувьд оновчтой сонголт болохгүй. Учир нь Монгол Улс үндэсний хуримтлал бага бөгөөд өрх, хувийн сектор болон улсын сектор хуримтлал хомс байдаг нь эдийн засгийн өсөлтийг хангах санхүүжилтээ гадаад эх үүсвэрээр бүрдүүлэх зайлшгүй шаардлагад хүргэдэг. Иймд хөрөнгийн чөлөөт урсгалд захиргааны хязгаарлалт тогтоох нь гадаад санхүүжилтийг хумих, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг бууруулах эрсдэлийг дагуулна. Төв банкны үндсэн зорилтыг “үнийн тогтвортой байдал” хэмээн олон улсын жишигт нийцүүлснээр Монголбанк төгрөгийн гадаад валюттай харилцах ханшийг огт анхаарахгүй болно гэсэн үг биш

юм. Нэг талаас, Монгол улсад хэрэглээний сагсны 40% нь импортын бараа бүтээгдэхүүнээс хамааралтай тул инфляци тогтвортой байхад ханшийн тогтвортой байдал чухал юм. Иймд ханшийн огцом хэлбэлзлэлийг зөөлрүүлэхэд чиглэсэн бодлогын одоогийн арга хэмжээ нь Төв банк үнийн тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд хэвээр хадгалагдах болно. Харин Монголбанкны үндсэн зорилтыг салаа утгагүй, олон улсын жишигт нийцүүлэн илүү нарийсган тодорхойлж өгснөөр Монголбанк үндсэн зорилттой нийцтэй бус бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрсдэлийг хязгаарлаж, илүү хариуцлагатай бодлого хэрэгжүүлэх хөшүүрэг болох болно. Нөгөө талаас ханшийн тогтвортой байдал нь санхүүгийн тогтвортой байдалтай уялдах тул Төв банк ханшийн богино хугацааны огцом савлагаанаас сэргийлэх арга хэмжээг үргэлжлүүлэн авах нь Төв банкны тухай хуулиар ногдсон Монголбанкны дагалдах зорилготой нийцтэй юм...

Мөнгөний бодлогын шийдвэр нь зээл, хүү, валютын ханш, хүлээлт, хөрөнгийн үнэ зэрэг гол сувгуудаар дамжин хэрэглээ, хөрөнгө оруулалт, гадаад худалдаа,

улмаар эдийн засгийн идэвхжилд нөлөөлж, инфляцид үзүүлэх нөлөө нь нэг жилээс урт хугацаанд үргэлжилдэг. Иймээс мөнгөний бодлогыг тодорхойлох, бодлогын үр нөлөөг тооцохдоо бусад төв банкууд ихэвчлэн гурван жилийн хугацаанд тооцож, хэмжиж байна. Гэтэл жил бүр Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд тусгагдсан инфляцийн зорилтыг дийлэнхдээ 3-аас цөөн жилээр УИХ-аас өөрчлөн тогтоож байв (Зураг 1). Мөнгөний бодлогын эцсийн үр дүн эдийн засагт бүрэн илрэхээс нь өмнө инфляцийн зорилтыг ийнхүү ойрхон давтамжтай өөрчлөх нь бодлогын нөлөөллийг бууруулах, дотоод, гадаадын зах зээл дээр тодорхой бус байдал үүсгэх, бодлогын үр дүнг хэмжих боломжгүй болгох зэрэг хүндрэлүүдийг үүсгэж байв. Иймд үнийн тогтвортой байдлыг хангахын тулд инфляцийг шат дараатай буулгах ерөнхий стратегийн хүрээнд инфляцийн зорилтыг мөнгөний бодлогын үр нөлөө илэрч амжихгүй богино хугацаанд буюу жил тутам шинэчлэх боломжтой байгааг өөрчлөх шаардлага үүсч байна...





ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДАЛ

Төв банкны хараат бус байдлыг хангаснаар нийгэм, эдийн засагт үзүүлэх ач холбогдол

Төв банкны удирдлагын хараат бус байдал хангагдсанаар бодлогын тууштай байдал хангагдаж, иргэд, олон нийтийн төв банк болон банкинд итгэх итгэл нэмэгдэнэ.

Инфляци урт хугацаанд нам тогтвортой түвшинд хадгалагдаж, эдийн засгийн өсөлт тогтворжиж, иргэдийн амьжиргаа өснө.

Валютын ханшийн талаар зохистой бодлого хэрэгжүүлснээр төгрөгийн ханш тогтворжиж, валютын нөөц нэмэгдэнэ.

Засгийн газартай хамтарсан ямар нэгэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхгүй, ЗГ-ын аливаа санхүүжилтийг хийхгүй байх нөхцөл баталгаажина.

Төв банкны хараат бус байдлыг алдагдуулснаар үүсч болох эрсдэл



Төв банкны зорилт нь тодорхойгүй, давхар утга илэрхийлдэг байх нь бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, олон нийтийн итгэх итгэлийг сулруулна.

Урт хугацаанд хэрэгжиж, үр дүнгээ өгөх бодлогод богино хугацаанд өөрчлөлт оруулснаар улс төрийн нөлөөллийг нэмэгдүүлнэ.



Мөнгөний бодлогын хорооны гишүүдийг богино хугацаанд өөрчлөх нь мэргэжлийн түвшинд тууштай ажиллахад хүндрэл үүсгэнэ.



ТӨВ БАНКНЫ БИЕ ДААСАН, ХАРААТ БУС БАЙДАЛ: БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ, БЭРХШЭЭЛ, СОРИАТ, ГАРЦ, ШИЙДЭЛ...

ТӨВ БАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ БҮРДҮҮЛЭХ, ЧИГ ҮҮРЭГ, БОДЛОГЫГ ТОДОРХОЙЛОХДОО ХАРГАЛЗАЖ ҮЗЭХ НЭГ ГОЛ ШАЛГУУР НЬ ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ МӨН ҮҮ?

Монголбанкны Эдийн засгийн шинжилгээ бодлогын хэлтийн захирал Б.Түмэнцэнгэл:

Юуны өмнө төв банк яагаад хараат бус байх ёстой юм бэ гэдэг асуултын хариулт их чухал. Төв банк гэдэг институц маань дэлхийн түүхэнд 350 орчим жилийн түүхтэй. Сүүлийн 30-40 жилийн хугацаанд төв банк гэдэг институц улс төр, Засгийн газраас хараат бусаар ажиллаж, мэргэжлийн шийдвэр гаргаж ажиллах нь эдийн засагтаа илүү сайн үр дүн авчирдгийг харуулсан маш олон судалгааны үр дүн бий. Ингэж чадаагүй нөхцөлд яадаг вэ гэхээр 1920-оод оны Германы жишээг хэлж болно. Үнэ дөрвөн өдөрт хоёр дахин нэмэгддэг. Сүүлийн жишээ бол Вэнэсуэль байна. Тэгэхээр энэ түүхийн явцад хүн төрөлхтөн юуг ойлгож авсан бэ гэхээр мөнгөний бодлогыг хэрэгжүүлж байгаа интитуцийн шийдвэр илүү алсыг харж, урт хугацаанд чиглэсэн байх ёстой юм байна. Ингэсэн тохиолдолд үнийн түвшин тогтвортой, эдийн засгийн өсөлт тогтвортой, банк, санхүүгийн систем эрүүл байна гэсэн дүгнэлтэд хүрсэн байгаа. Үүний цаана буй эдийн засгийн агуулгаараа юу гэсэн үг вэ гэхээр цаг хугацааны нийцгүй байдал гэж бий. **Аливаа бодлого түр зуурын, богино хугацаанд хэрэгжих, олон нийтэд таалагдах гэсэн чиглэлтэй байж болохгүй.** Ирээдүйд тухайн улсын эдийн засагт

юу чухал байна вэ, түүнд чиглэх нь зүйтэй. Төв банкныг энэ зүйл рүү чиглүүлэхийн тулд хараат бус байдлыг хангах нь чухал гэж дэлхий нийт үзэж байгаа.

ЭРХ ЗҮЙН ХУВЬД ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫГ ЯМАР ХҮРЭЭНД ТОДОРХОЙЛОХ ЁСТОЙ ВЭ. ҮНДСЭН ХУУЛИЙН ТҮВШИНД АВЧ ҮЗЭХ ШААРДЛАГАТАЙ ЮУ, ЭСВЭЛ ЕРДИЙН САЛБАР ХУУЛИАРАА ЗОХИЦУУЛАХ НЬ ЗӨВ ҮҮ?

Б.Түмэнцэнгэл:

Төв банкны хараат бус байдлын асуудлыг Үндсэн хуулиндаа тусгасан улс орнууд бий. Гэхдээ ихэвчлэн төв банкинд зориулсан тухай хуулиар нь хараат бус байдлыг хангаж өгдөг. Хуулиар хангаснаар энэ нь бүрэн хангалттай юу гэвэл бас тийм биш. Хуулийг хэзээ ч өөрчлөх боломжтой. Тэгэхээр **төв банкны хараат бус байдлыг хангах үндсэн зүйл нь олон нийтийн зөв ойлголт.** Энэ институци улс төрөөс хараат бусаар ажиллаж, мэргэжлийн шийдвэр гаргахад олон нийтийн зөв ойлголт мөн хамгийн чухал байдаг.

Хуульч, судлаач Ж.Сайнхишиг:

Төв банкны гол зорилго нь үнийн тогтвортой байдлыг хангах. Чиг үүргийн хувьд харьцангуй мэргэжлийн шинжтэй. Тийм учраас хараат бусаар үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Олон улсад судлаачид төв банкны хараат бус байдлын эрх зүйн зохицуулалтыг 3-4 үзүүлэлтээр авч үзэж байна. Түүгээр нь авч үзээд, **манай улсын төв банкны хараат бус байдлыг үнэлбэл, ерөнхийдөө хангалтгүй үзүүлэлт гарч ирж байгаа.** Жишээлбэл, удирдлагын бүрэн эрхийн хугацаа,

томилгооны асуудал. Энэ бол төв банкны бүтцийн хувьд улс төрөөс тусгаарлах гол арга хэрэгсэл. Гэтэл манай улсад төв банкны ерөнхийлөгчийг 6 жилээр томилдог боловч, 1991 оноос хойших төв банкны ерөнхийлөгч нарын бүрэн эрхээ хэрэгжүүлсэн дундаж хугацаа нь 3.7 жил байна. Тэгэхээр энэ нь хуулийн заалт хэрэгжихгүй байна гэсэн үг. Мөн удирдалгаар нь дамжуулаад, нөлөөлөх магадлал өндөр. Дараагийн асуудал бол шийдвэр гаргалтад бусад субъектээс нөлөөлж байна уу, үгүй юу. Үүнд ялангуяа УИХ, Засгийн газартай төв банк харилцах асуудал байгаа. Үүн дээр манай улсад бас л тодорхой асуудал байгаа нь судалгаагаар харагдаж байгаа. Дэлхийн улсуудад төв банк шийдвэр гаргах гол зорилго нь мөнгөний бодлогоо тодорхойлох шүү дээ. Гэтэл манайд мөнгөний бодлогоо тодорхойлохыг нь улс төрийн институц буюу парламент хэрэгжүүлээд байна. Ийм улс их цөөхөн. Нэгдүгээрт, өөрөө шийдвэр гаргах анхны чиг үүрэг нь дутмаг байна. Хоёрдугаарт, Засгийн газраас нөлөөлөл тодорхой хэмжээнд бий. Төсвийн шинжтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэх ч юм уу. Тэгэхээр шийдвэр гаргах бүрэн эрх нь бас л эрх зүйн хувьд асуудалтай байна гэсэн үг.

БИЕ ДААСАН, ХАРААТ БУС БАЙДЛЫГ ЯМАР ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД АВЧ ҮЗЭЖ, ТОДОРХОЙЛОХ ШААРДАЛАГТАЙ ВЭ?

Ж.Сайнхишиг:

Ерөнхийдөө дэлхийн 46 улсыг хамруулсан судалгаанаас үзэхэд 22 улсад Үндсэн хуулийнхаа төвшинд төв банкны асуудлыг зохицуулсан байна. Энэ нь голцуу эх газрын эрх зүйн тогтолцоотой, европын уламжлалтай улсууд юм. Манай улсын хувьд Үндсэн хуулинд байхгүй. 1996 онд батлагдсан төв банкны тухай хуулиар зохицуулагдаж байгаа. Хуулийг хэзээ ч өөрчилж болно гэдгийг сая төв банкны ажилтан хэллээ шүү дээ. Ялангуяа, манайх шиг хөгжиж буй улсын хувьд ямар ч хуулийг хэзээ ч гаргаж болзошгүй, хөгжлийн зовлон байна. Тэгэхээр **манай улсын хувьд төв банкны асуудлыг органик хуулиар зохицуулж байгаа нь төв банкны хараат бус байдлыг алдагдуулах нэг хүчин зүйл болж таараад байна.** Уг нь хуулиар зохицуулаад, тэрнийг сайн мөрдөөд явдаг бол асуудал байхгүй л дээ. Гэхдээ манай улсын хувьд асуудал арай өөр түвшинд яригдаад байгаа юм.

Эдийн засагч Д.Жаргалсайхан:

Хэнээс хараат бус байх ёстой вэ. Төв банкны үүрэг юу вэ гэдгийг дахиж ярих ёстой. Эдийн засгийн харилцааг мөнгөөр зохицуулдаг. Мөнгө нь эдийн засагт их, бага ямар хэмжээнд байх вэ гэдгийг бодлогын хувьд төв банк зохицуулах ёстой. Ер нь бол төв банк арилжааны банкуудаараа дамжуулаад, тэднийг хянах замаар энэ ажлыг хийх ёстой. Гэтэл энэ нь төв банкнаас хамаарахгүйгээр, Засгийн газар төв банкаар ажил хийлгэдэг. Ялангуяа, 2012 онд Засгийн газар төв банкаар төсвийн ажил хийлгэсэн. Нэгэнт мөнгөний хэмжээг хянахын тулд эдийн засгийн хамгийн том тоглогч болох Засгийн газар, Сангийн яамнаас нийлүүлж байгаа мөнгөний хэмжээ их, бага байна шүү гэдгийг хянаж, хэлэх ёстой байтал, тэдэнтэйгээ цуг, хамтарч ажиллаад явсан. Юун хараат бус байх, эсрэгээрээ хамтарч ажиллаад, мөнгө хэвлээд, тэрнийх нь үр дүнд төгрөгийн ханш нь унаад, иргэд нь тэр төлбөрийг төлөөд явж байна л даа. Тэгэхээр өнөөдөр ч бас Монголбанк бүрэн хараат бус байна уу, үгүй юу гэдэг асуудал гарч ирнэ. Бас л бүрэн хараат бус байж чадахгүй байна. Долларын ханш нэмэгдэж байна. **Интервэнц хийж, наад мөнгөө зар гээд шахаж байна.** Гэх мэтээр ийм байдалд байгаа. Нөгөөтэйгүүр арилжааны банкууд төрөөс хэтэрхий хамааралтай, төрийн их хэмжээний мөнгөн дээр л тоглож байгаа. Энэ бүхнээс хамаараад, төв банкны үйл ажиллагааг бүрэн, жигд явуулахад амаргүй байна. Инфляци Монгол Улсад 7-8 хувь байна. Үүнийг сайн байна гээд магтаад байх хэрэггүй. 7-8 хувь гэдэг чинь бас л өндөр тоо. Яах вэ, 40-50 хувьтайгаа харьцуулахад бага тоо л доо. Гэхдээ инфляцийг төр засаг өөрсдөө үйлдвэрлээд, бүх хүмүүсийн мөнгийг 7-8 хувиар нь дээрэмдэж байгаатай л адил шүү дээ. Тийм учраас би төв банкны ажил явахгүй байна гэж хэлээд байгаа юм.

СЭЗИС-ийн багш Д.Түвшинжаргал:

Манайх шиг эдийн засагтай улс орны хувьд нэгдүгээрт, улс төрийн асуудал их яригддаг. 1980-аад оноос хойш эдийн засгийн онолд "Шинэ улс төрийн макро экономикс" гэсэн ойлголт гарч ирсэн. Энэ нь юу вэ гэхээр бидний мэддэг уламжлалт Кэйнсийн онолоос яг эсрэгээрээ. Кэйнс юу гэдэг вэ гэхээр Засгийн газар, төв банк нь эдийн засагт гал унтраах, тогтворжуулах

үүрэгтэй гэж үздэг. Харин **“Улс төрийн макро экономикс”-т бол улстөрчид богино хугацаанд дахин сонгогдохын тулд эдийн засгийг донсолгодог** гэж байгаа. Тухайлбал, 2018 онд Батсүх, Өнөр гээд хоёр хүний хийсэн судалгаа бий. Манай улсын 1991-2017 оны хооронд болсон сонгуулийн мэдээлэл дээр тулгуурлаад, Засгийн газар манипуляц хийж байна уу, үгүй юу гэдгийг харсан. Эндээс ажиглагдсан нэг үр дүн нь 2008 оноос хойших сонгуулиудад манай засгийн газар сонгуулийн өмнө манипуляц хийдэг юм байна. Тухайлбал, цалингаа өсгөдөг, төсвийн алдагдлаа нэмэгдүүлдэг. Хоёр дахь гол ажиглагдсан зүйл нь хэдийгээр сонгуулийн өмнө манипуляц хийсэн ч гэсэн энэ нь сонгуулийн үр дүнд их нөлөө үзүүлдэггүй. Энэ нь нийгэмдээ ямар нөлөө үзүүлдэг вэ гэхээр дараагийн Засгийн газартаа санхүүгийн дарамт үлдээдэг юм байна.

Хоёр дахь миний онцолж байгаа зүйл юу гэхээр **байгалийн баялагтай орнуудад Засгийн газар нь төв банкаа хараандаа байлгах маш их сонирхолтой байдаг.** Ийм факт байна. Энэ нь ч эргээд тоон статистикууд, сүүлийн жилүүдийн эдийн засгийн гүцэтгэл, төв банкны өмнөх ерөнхийлөгч нарын хийсэн ажлуудыг харвал үндсэндээ нотлогдсон гэж хэлж болохоор байна.

ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫГ ТОГТООХДОО, УЛС ТӨРӨӨС АНГИД БАЙХ, ЗАСГИЙН ГАЗРААС ХАРААТ БУС БАЙХАД ЯГ ЯМАР ХЯЗГААРЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫГ ХИЙЖ ӨГӨХ ЁСТОЙ ВЭ?

Д.Түвшинжаргал: Төв банкны хувьд эдийн засгийн өмнө хүлээж байгаа гол хариуцлага нь инфляцийг тогтвортой байлгах. Энэ нь дам утгаараа эдийн засгийн өсөлтийн суурь, дэвсгэр нь болно гэсэн үг. Бусад чиг үүргүүдийг Засгийн газар хариуцна гэсэн үг.

Монголбанкны хараат бус байдлын талаар судлаач, эдийн засагч нартай ярилцахад дээрх байр суурийг илэрхийлцгээж байна. Төв банк бол цэвэр мэргэжлийн институци гэдэг утгаараа үйл ажиллагаа нь хараат бус байх ёстой ч манай улсын хувьд ялсан намын

шийдвэрийг төв банкиндаа тулгах гэсэн оролдлого нь Төв банкны эдийн засгийнхаа тогтвортой байдлын эсрэг буруу бодлого явуулахад хүргэж, түүхэндээ томоохон сургамжийг аваад байгаа билээ.

Судлаачид Төв банкны хараат бус байдлыг үндсэн 3 хэмжүүрээр хэмжжээ. Зорилгын хувьд хараат бус, зорилгоо биелүүлэх арга хэрэгслийн хувьд хараат бус, үйл ажиллагааны хувьд хараат бус гэж. Иймд төв банкны хамгийн эмзэг асуудал болсон төв банкны удирдлагын томилгоотой холбоотой асуудал бол үйл ажиллагааны хараат бус байдал дээр тусч байна. Мөнгөний бодлогын үйл ажиллагааг хэрэгжүүлж буй албан тушаалтныг хэрхэн томилж, хэрхэн огцруулж байна вэ гэдэг асуудал.

Шигтгээ: Төв банк (Монголбанк)-ны хууль 2018 онд шинэчлэгдэв. Үүнд орсон гол өөрчлөлт нь төв банкны засаглал, институцийн тогтолцоог сайжруулахад оршив. Мөнгөний бодлогын шийдвэрийг нэг эрх мэдэлтэй албан тушаалтанд хариуцуулах биш, Мөнгөний бодлогын хороогоор гаргадаг болгов. Энэ нь дэлхийн 90 гаруй орны төв банкны практикт байдаг сайн засаглалын туршлага юм.

Энэ утгаараа төв банкны үйл ажиллагаанд сайн засаглалын элемент нэвтэрсэн гэж үзэж байгаа. Зорилгын хараат бус байдлын хувьд төв банкны хэрэгжүүлж буй мөнгөний бодлого нийгэмд маш том нөлөөтэй зүйл. Үүнийг төв банк гэдэг сонгогддоггүй, олон нийтийг төлөөлдөггүй институцид хариуцуулах нь том эрсдэл дагуулна. Тэгэхээр үүнийг зорилгын хувьд хязгаарлаад, зөвхөн үнийн тогтвортой байдал гэдэг зүйлд төвлөрүүлж, энэ хүрээнд л мөнгөний бодлогоо хэрэгжүүлнэ шүү гэдгийг тогтоож өгч байна гэсэн үг. Нөгөө талаас олон нийтэд нээлттэй, бодлогоо хэрэгжүүлж байна вэ гэдгийг олон нийтэд тайлагнаж байхыг шаарддаг. Тэгэхээр хараат бус байдал гэдэг нь бүх хүнээс хараат бус байгаад, хаалгаа хаана гэсэн үг биш. Хараат бус байдалтай хамт нээлттэй, ил тод байдал байх ёстой. Энэ хоёр зүйл нэг зоосны хоёр тал юм.

Эх сурвалж: МҮОНТВ



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ НАРЫН АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Монгол Улс хоёр шатлалт банкны тогтолцоонд шилжин Төв банк (Монголбанк)-тай болсноос хойш Төв банкны хуулийн дагуу УИХ-аас томилогдсон 8 ерөнхийлөгч Төрийн мөнгөний бодлогыг удирдаж, найм дахь Ерөнхийлөгчөөр Н. Баяртсайхан ажиллаж байна. Тэдний үүрэг гүйцэтгэсэн байдлаас үзэхэд О.Чулуунбат агснаас бусад нь хуулиар олгогдсон 6 жилийн бүрэн эрхийн хугацаагаа гүйцээж чадаагүй байна. Тэдгээр Ерөнхийлөгч нарын нэг нь үүрэгт ажлаа хангалтгүй хийсэн гэдэг үндэслэлээр чөлөөлөгдөж байсан бол бусад нь чөлөөлөгдөх хүсэлтээ өгснөөр бүрэн эрхийнхээ хугацааг гүйцээгээгүй ажээ.



Н.ЖАРГАЛСАЙХАН
(1991-1992)



Д.МОЛОМЖАМЦ
(1992-1996)



Ж.ҮНЭНБАТ
(1996-2000)



О.ЧУЛУУНБАТ
(2000-2006)



А.БАТСҮХ
(2006-2009)



Л.ПҮРЭВДОРЖ
(2009-2012)



Н.ЗОЛЖАРГАЛ
(2012-2016)



Н.БАЯРТСАЙХАН
2016 ОНООС

ХАРААТ БУС ТӨВ БАНК ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

“Хараат бус төв банк” гэдэг нь эдийн засагт мөнгө нийлүүлэх онцгой эрхийг улстөрийн нөлөөнөөс ангид байлгаж, зохистой мэргэжлийн байгууллагад даатгахыг л хэлж буй хэрэг юм. Учир нь мөнгөний бодлогын шийдвэр мэргэжлийн байснаар ард иргэдийн амьжиргаа, сайн сайхан байдал дээшилдэг, харин ингэж чадаагүй улстөрчдийн нөлөөлөлд автсан тохиолдолд эдийн засаг доройтож, ард олноороо хохирсон туршлагыг олон улс орны жишээ тодхон харуулдаг. Тийм ч учраас дэлхийд анхны төв банкууд үүссэнээс хойшхи 350 гаруй жилийн хугацаанд эдийн засагчид бүрэн санал нийлдэг цөөхөн зүйлийн нэг бол “хараат бус төв банк” юм.

Мөнгө хэвлэх нь хөгжлийн гарц биш

Мөнгө хэвлээд л улс орон хөгжихдөг бол дэлхийн бүх улс маш амархан баян тансаг амьдрах байв. Гэвч төв банкаар мөнгө хэвлүүлээд хөгжил дэвшилд хүрдэггүйг эдийн засгийн онол зааж, түүх нотлоод хэдэн зуун жил болжээ. 1920-оод оны Германд уушийн газарт пиво нь бүлээсэхээс өмнө үнэ нэмэгдчихдэг байв. 2008 оны Зимбабвед мөнгийг килограммаар хэмждэг байсан гэдэг. Одоо Венесуельд төлөх мөнгө нь авах 00-ийн цааснаасаа их овор хэмжээтэй болсон. Эдгээр нь хэт их мөнгө хэвлэсний л уршиг юм. Мөнгө өөрөө эдийн засаг дахь үйлдвэрлэл үйлчилгээ буюу баялгийг хэмждэг нэгж болохоос, өөрөө баялаг бүтээмж биш юм. Мөнгө хэвлэснээр баялаг бүтээгддэггүй учраас шинээр баялаг бүтээгдээгүй байхад хэвлэсэн мөнгө үнэ цэнээ алдаж цаас болно. Гэвч улстөрчид ихэвчлэн сонгуулийн өмнө ард түмэнд таалагдах гэсэн харалган бодлогыг төв банкинд тулган мөнгө хэвлүүлж санхүүжүүлснээр эдийн засагтаа, иргэдийнхээ амьжиргаанд том сөрөг үр дагаврыг үзүүлсэн тохиолдол их. Харин үүнээс сэргийлэх хамгаалалт нь хараат бус төв банк юм. Аливаа улстөрч мөнгөний бодлогод нөлөөлөх оролдлогыг эдийн



засгийн тогтвортой байдал, ард түмнийхээ эрх ашгийн эсрэг үйлдэл гэж харахаас өөр аргагүй.

Монголбанкны хараат бус байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг зааснаар хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг нийгэм хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх нь төрийн үүрэг мөн. Төр энэ үүргийнхээ дагуу хүний хувийн өмч, хөрөнгийн үнэ цэнэ, ирээдүйд итгэх итгэлийг инфляци, эдийн засгийн тогтворгүй байдлаас хамгаалах дархлааг 1996 оны Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийг баталсан ч улс төр, эдийн засгийн богино хугацааны ашиг хонжоо нь хуулийн үзэл баримтлалыг бүдгэрүүлж, бодлогын тууштай байдлыг алдагдуулсаар иржээ. Монголын улстөрчид Монголбанкыг “мөнгөний авдар” гэж харсаар ирсэн нь үүнийг гэрчилнэ. Хамгийн сүүлийн жишээ гэхэд 2016 оны сонгуулиар Төв банкаар 374 тэрбум төгрөг хэвлүүлэн “сайн хувьцаа” нэрээр сонгуулийн насны иргэдэд 300 мянган төгрөг бэлнээр тарааж байв. Энэ нь улстөрийн дарамтан дор 2012-2016 онд Монголбанкнаас хэрэгжүүлсэн 7.2 их наяд төгрөгөөр хэмжигдэх “төсвийн шинжтэй” үйл ажиллагааны зөвхөн нэг хэсэг байв. Үр дүнд нь төгрөгийн ханш 2 дахин суларч, Монгол улс 7 тэрбум ам.долларын валютын нөөцийг салхинд хийсгэж, эдийн засаг дампуурлын ирмэгт хүрч олон улсын байгууллагуудын тусламжаар аврагдсаныг бид мэднэ.

Мөнгөний бодлогод улстөр ингэж халддаг нөхцөлд Төв банкны хараат бус байдлыг

хуулиар хэрхэн хамгаалсныг үнэлэх судалгаануудын үр дүнгээр Монголбанкны бие даасан, хараат бус байдал 100 онооноос 40-60 хувьтай буюу “муу” түвшинд гэж үнэлэгдэж байлаа. Хуулийн хамгаалалтын сул байдал бодит амьдрал дээр ч харагдаж, сүүлийн 30 жилд Монголбанкны ерөнхийлөгчийн бүрэн эрхийн 6 жилийн хугацаагаа дуусгасан тохиолдол ердөө 1 байсан байна. Өөрөөр хэлбэл, улстөрчдийн үгэнд ороогүй Төв банкны ерөнхийлөгчийг үгэнд ордог хүнээр солих бололцоо нээлттэй байсаар.

Монголбанктай хариуцлага тооцох нь

Мөнгөний бодлого эдийн засагт, ард олны амьжиргаанд хүчтэй нөлөөлдөг тул энэ эрх мэдлийг хэнд олгох вэ гэдгийг ард түмнээс мандат авсан парламентаас шийдэх нь түгээмэл. Гэхдээ төв банкны удирдлагыг нэгэнт томилсон бол хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх улс төр, хууль зүй, санхүүгийн нөхцөлөөр хангасан байх нь бие Төв банкны даасан, хараат бус байдлын талаарх олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, тогтсон шилдэг туршлагад тооцогддог. Иймдээ ч Төв банкинд хуулиар ногдуулсан чиг үүрэгт нь хамаарахгүй асуудлаар хариуцлага ногдуулах нь төв банкны бие даасан байдалд халдаж буй хэрэг гэж үзнэ. Монгол Улсын мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тогтолцоонд олон улсын байгууллагаас өгсөн үнэлгээний “саарал жагсаалт”-ын асуудлаар Монголбанкны удирдлагыг албан тушаалаас чөлөөлөх асуудлыг хөндөх нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуультай зөрчилдөнө.

Монголбанкны гол үүрэг ба биелэлт

Монголбанкны үндсэн зорилтыг “төгрөгийн тогтвортой байдал”, дагалдах зорилтыг “санхүүгийн тогтвортой байдал” хэмээн хуулиар зааж өгсөн байдаг. Төгрөгийн тогтвортой байдлыг цөөнгүй хүн “төгрөгийн ханшийг тогтоох” гэж ойлгодог ч, энэ нь алдаатай юм. Мөнгөний бодлогын гол зорилт нь олон улсын жишгээр “үнийн тогтвортой байдал” буюу инфляци байдаг бөгөөд Монголын хувьд инфляцийн зорилтот түвшнийг УИХ-аас баталж өгдөг. Иймээс эдийн засагт үнийн түвшин хэлбэлзэж өөрчлөгдөхөд инфляцийг зорилтот түвшинд эргүүлж авчрах нь мөнгөний бодлогын гол үүрэг болно. Ханшийн бодлогын хувьд, Монголбанк гадаад валют үйлдвэрлэдэггүй тул ханшийг тогтоох бус харин эдийн засгийн фундаменттай нийцгүй огцом савлагааг үүсгэхгүй байлгахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд, энэ нь валютын нөөцөөс ихээхэн хамааралтай. Валютын нөөц бүрдүүлэхэд экспорт хийх, гадаадын шууд хөрөнгө оруулалт татах замаар валют олох нь чухал бөгөөд энэ нь хууль эрх зүйн орчин, эдийн засгийн салбаруудыг зохицуулж буй бодлого зэргээс ихээхэн шалтгаална. Харин дагалдах зорилт буюу санхүүгийн тогтвортой байдал хангагдаж байгаа нь эдийн засагт санхүүгийн зуучлал хэвийн явагдаж байгаа эсэхээс харагддаг байна. Иймд Төв банк ажлаа хэр сайн эсвэл муу хийснийг дүгнэхэд инфляцийг тогтвортой байлгахад, санхүүгийн системийг тогтвортой байлгахад чиглэн юу хийсэн бэ, ямар үр дүнд

хүрсэн бэ гэдгээр л хэмжинэ гэсэн үг.

Монголбанк ямар алдаа хийсэн бэ?

Монголбанк дангаар болон төрийн бусад байгууллага, олон улсын эдийн засаг, санхүүгийн байгууллагатай хамтарч үр дүнтэй ажиллаж, макро эдийн засгаа уналтаас босгож ирснийг олон эерэг үзүүлэлт, мэргэшсэн эдийн засагч, судлаачид нотолно. Ялангуяа, Төв банкны үндсэн зорилт хангагдан эдийн засаг сэргэлтийн дунд, инфляци Төв банкны зорилтот түвшний орчимд тогтвортой байгаа нь мөнгөний бодлого зөв явж буйн илрэл юм. Үүнд 2016-2019 онд үнэ ханшид сөргөөр нөлөөлж байсан төсвийн шинжтэй үйл ажиллагаа буюу улстөрийн нөлөөллөөр эмх замбараагүй мөнгө хэвлэж байсныг зогсоосон нь чухал нөлөөтэй байв. Мөн Монголбанк мөнгөний бодлогыг олон улсын сайн жишгээр сахилга баттай хэрэгжүүлснээр зээлийн хүү 2011 оноос хойшхи хамгийн доонд түвшин хүрч буурч, банкны санхүүжилтүүд нэмэгдэн эдийн засгийн өсөлтийг тэтгэсэн. Төв банк ийнхүү сахилга баттай ажиллаж байгаа нь бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлж, улсын зээлжих зэрэглэл өсч, хөрөнгө оруулалт татахад ч чухал байв. Нөгөө талаар, санхүүгийн тогтвортой байдал ч мөн хангагдаж, арилжааны банкууд санхүүжилтээ хэвийн гаргаж байгаагийн зэрэгцээ банкуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх чиглэлд хийсэн активын чанарын үнэлгээ, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх арга хэмжээнүүд нь чөлөөт зах зээлд

шилжсэнээс хойшхи түүхэнд анх удаа хийгдсэн том ажлууд бөгөөд цаашдын эдийн засгийн тогтвортой байдалд чухал байх болно. Түүнчлэн, Монголбанкны засаглал институцийг сайжруулах, банкны салбарыг илүү бат бэх байлгахад чиглэсэн хуулийн реформууд, валютын нөөцийг 3 дахин нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, Төв банкны алдагдлыг 2 дахин бууруулсан зэрэг нь өнгөрсөн 3 жилийн төв банкны ажлын үр дүн гэж дүгнэгддэг.

Харин одоо төв банк сонгуулийн өмнөх улстөрчдийн дайралтыг тэсч үлдэж чадах уу, улстөрчид Монголбанкны удирдлагыг солиод мөнгө хэвлэн эдийн засагтаа хор хүргэх зүйлийг хийх үү гэдэг замын уулзвар дээр байна. Төв банкны хараат бус байдлын эцсийн хамгаалалт нь олон нийтийн дундах зөв мэдлэг, мэдээлэл байх болно.

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайханыг огцруулах тухай асуудлыг зарим УИХ-ын гишүүн болоод сөрөг хүчнээс сүүлийн гурван жилд хэдэнтэй тавьсан ч түүний эрхэлж буй үйл ажиллагаатай нийцэхгүй байлаа. Харин УИХ-ын даргаас Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх FATF олон улсын байгууллагын хяналтад орсон нь Монголбанкны Ерөнхийлөгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх саналыг УИХ-д тавиад байна. Энэ нь хууль зүйн үндэслэлтэй эсэхэд мэргэжлийн судлаач, эдийн засагчид эсрэг байр суурийг илэрхийлж байгаа билээ.

ХЭН ЮУ ХЭЛЭВ?



**Монголбанкны Ерөнхийлөгч
асан А.БАТСҮХ**

Хамгийн чухал нь эдийн засгийнхаа бүтцийг сайжруулж байж л төв банкны бие даасан байдал хангагдана. Эдийн засгийн бүтэц сул байгаа учраас өнөөдөр зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох, итгэлийн зээл олгох гэх зэрэг популист сэдэв гарч ирээд байна. Бүтцээ сайжруулах гол ажил нь төрд л бий.



**Ромын философич
ЦИЦЕРОН**

Хамгаалагчдыг хэн хамгаалах вэ?



**Монголбанкны Ерөнхийлөгч
асан Л.ПҮРЭВДОРЖ**

Ер нь бол төв банкны ерөнхийлөгчийг сонгуульд ялсан намын Их хурлын дарга нь “Одоо би тантай ажиллахгүй, та өргөдлөө өг” гээд л халчихдаг. Хувь хүнийхээ хувьд нэгэнт бодлого, чиглэл нийлэхээргүй болсон, тийм нөхцөлд ажлаа өгсөн нь дээр л дээ. Харамсах зүйлгүй. Харин улс орны хөгжил, тогтвортой байдал талаасаа харвал энэ маш муухай жишиг.



**ХНС-ийн тэргүүн асан
БЕН БЕРНАНКЕ**

Ухаалаг, хараат бус төв банк нь Хөрөнгийн зах зээлийн уналтаас үүдэлтэй гаж нөлөөллөөс эдийн засаг болон санхүүгийн секторыг хамгаалж чадна гэдгийг түүх нотолж байна”

Төв банк нь богино хугацааны улс төрийн шийдвэрээс ангид бодлого гаргах чадвартай байх шаардлагатай.



**Монголбанкны Ерөнхийлөгч
Н.БАЯРТСАЙХАН**

Аливаа улс орон эрүүл банктай байж эрүүл саруул эдийн засгийн амьдралыг бүрдүүлнэ. Энэ нь цаашлаад эрүүл улс төр, эрүүл нийгмийн үндэс суурь болно. Улс төр бол эдийн засгийн шууд тусгал, хураангуй илрэл шүү дээ.



**ОХУ-ын төв банкны Тэргүүн
ЭЛВИРА НАБИУЛЛИНА**

“Төв банк эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх чадвартай байна гэдэг нь бие даасан байдлаа алдана гэсэн үг биш”.



**ОУВС-ийн Ерөнхий эдийн засагч
ГИТА ГОПИНАТ**

“Хэрэв өрийн хямрал нь зах зээлийн уналтаас бус засгийн газрын луйвар, буруу менежментээс үүдэлтэй бол төв банк хөндлөнгөөс оролцохгүй байх нь зөв”.



**ХБНГУ-ын Канцлер АНГЕЛА
МЕРКЕЛЬ**

Туркийн эдийн засгийг тогтворгүй байлгах сонирхол хэнд ч байхгүй. Гэхдээ бүх зүйлийг гүйцэлдүүлэе гэвэл Туркийн Төв банкыг хараат бус байдлаар хангах хэрэгтэй



**ING банкны Герман дахь
Ерөнхий эдийн засагч
КАРСТЕН БРЗЕСКИ**

Төв банкинд шахалт үзүүлэх, тэднийг шүүмжлэх шинэ хандлага бидний дунд ихээхэн газар аваад байна. Тэд бол эдийн засгийн хамгаалагчид



**Энэтхэгийн нөөцийн банкны 23
дахь Ерөнхийлөгч
РАГУРАМ РАЖАН**

Сайд, улс төрийн өндөр албан тушаалтан, болон бусад зохицуулагчдаас Төв банкны ерөнхийлөгчийн ялгарах гол ялгаа нь тэрбээр эдийн засгийн хамгийн чухал бодлогын хөшүүргийг удирдах эрхтэй байдаг бөгөөд зарим үед улс орны хамгийн нөлөө бүхий хүмүүстэй санал зөрөлдөх шаардлага тулгардаг



**Энэтхэгийн нөөцийн банкны 21
дахь Ерөнхийлөгч
ВЕНУГОПАЛ РЕДДИ**

Энэтхэгийн засгийн газар дахиад нэг бие даасан институцэд халдаж эхэллээ. Тэр нь Энэтхэгийн Нөөцийн банк бөгөөд санхүүгийн хараат бус байдалд нь ноцтойгоор халдаж Төв банкнаас ногдол ашиг хүртэх замаар төсвийн алдагдлыг нөхөж байна.



**АНУ-ын Ерөнхийлөгч
ДОНАЛД ТРАМП**

Одоогийн байдлаар Холбооны Нөөцийн банк нь өөрөө Хятад улсаас илүү том асуудал болж байна. Тэдний хэрэгжүүлж байгаа бодлогуудыг оновчгүй байна гэж би үзэж байна. Хүүгийн түвшинтэй холбоотойгоор хийгдэж буй алхмууд нь надад таалагдахгүй байгаа. Тэдний зүгээс энэ тал дээр огт тохиролцох хүсэлгүй байна. Хэдий миний зүгээс худалдааны гайхалтай хэлэлцээрүүдийг хэрэгжүүлж байгаа ч Холбооны Нөөцийн банк огт дэмжлэг үзүүлэхгүй байна.



**АНУ-ын Холбооны нөөцийн
банкны тэргүүн
ЖЕРОМЕ ПОВЕЛЛ**

Улс төрийн хүчин зүйлүүд АНУ-ын Холбооны нөөцийн банкны үйл ажиллагаанд огт хамааралгүй бөгөөд манай хамт олон болон миний зүгээс, бидний шийдвэр гаргах, санал солилцох үйл явцад нөлөөлөх гэсэн оролдлогыг үл тэвчих болно.



Нийтлэлч **Б.БАТБАЯР**

2018.12.24

1991 онд Бямбасүрэнгийн Засгийн газраас монгол төгрөгийн ханшийг хоёр дахин унагах 20 дугаар тогтоол гарсныг ихэд муулдаг. Монголд байрлаж байсан 100 мянган зөвлөлт цэрэг, тэдний эхнэр хүүхдийн дунд Ленинград хэвлэгддэг төгрөг хичнээн байсныг Монголын ганц байсан банк нь мэддэггүй байсан. Тэдний гар дээр байгаа мөнгөний ханшийг огцом унагаж байж нийт төгрөгийнхөө баримжааг олж мэдэн удалгүй шинэ эмисс хийсэн нь тухайн үедээ тун оновчтой, эдийн засгийн хувьд зайлшгүй хийх ёстой байсан арга хэмжээ юм. Тэрний дараа л үнэнгээсээ Монголд анхны үндэсний Төв банк байгуулагдсан юм шүү дээ.

Төв банк (зарим газар “Нөөцийн банк”, “Мөнгөний мэдэл” гэх мэтээр нэрлэдэг) бол улсын валют, хүү, мөнгөний нийлүүлэлт зэрэгт мэнэжмент хийдэг бие даасан инстүүц юм. Төв банк нь мөн тухайн улс орон дахь арилжааны банкны тогтолцоо, хандлагыг тодорхойлох үүрэгтэй. Арилжаны банкнаас ялгаатай нь мөнгөний суурийг тэлэх онцгой эрх эдэлдэг, иймээс ч өөрийн бодлогын хүрээнд тухайн улсын баталгаажсан мөнгөн тэмдэгийг хэвлэн гүйлгээнд оруулах эрхтэй. Төв банк нь санхүүгийн хямралын үед “сүүлчийн арга хэмжээ” гэгдэх арилжааны банк болон санхүүгийн бусад байгууллагад бэлэн мөнгө гаргаж өгөх “аргагүй хамгаалалт” хийх эрхтэй байдаг. Арилжааны банкуудыг хянаж зохицуулж байх үүргийнхээ хүрээнд шаардлагатай үед тэдний дампуурлыг зарлах, хаах эрх эдлэнэ.

Тогтворжсон тогтолцоотой орнуудад Төв банкныг улс төрийн нөлөөнөөс ангид байлгах аар зохион байгуулан зохицуулсан байдаг. Энэ нь төрийн гүйцэтгэх ба хууль тогтоох инстүүцээс аль болох ангид, тэдний хяналт маш хязгаарлагдмал байхаар зохицуулжээ. Бие даасан байдал гэдэг нь Төв банк өөрийн бодлогоо хөндлөнгийн инстүүц болон хүний оролцоогүйгээр шийдэх эрхийн тухай яриа.

Төв банк нь эдийн засгийн ба улс төрийн хараат бус байдлаар бие даасан шинжээ хадгална. Эдийн засгийн хараат бус байдал гэдэг нь Төв банк мөнгө зээлийн бодлогоо ямар ч хязгаарлалтгүйгээр бие даан шийдэж өөрийн тавьсан зорилгоо хэрэгжүүлэхийн тулд авах арга хэмжээгээ өөрөө сонгон шийднэ. Улс төрийн бие даасан байдал гэдэг нь Төв банк

удирдлагаа сонгох, мөнгө зээлийн бодлогоо боловсруулахдаа Засгийн газартай зөвлөлдөх шаардлагагүй. Хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал нь Төв банкны орлогын хуваарилалтад оролцох, удирдлагын сонголтод нөлөөлөх, Төв банкны мөнгө зээлийн бодлогод нөлөөлсөн хууль гаргах, Төрийн зардлыг шууд ба шууд бусаар Төв банкаар санхүүжүүлэх сонирхолтой байдаг учир энэ болгоныг нэг бүрчлэн хориглосон хуулийн хүрээнд ажлаа явуулах ёстой.

Монгол улсын хууль тогтоомжоор Монгол банк нь (манай Төв банкны оноосон нэр шүү дээ) Улсын их хурлын удирдлагад байдаг. Уг нь энэ нь ерөнхий хяналт болохоос бодлого болон ажил төрөлд нь хөндлөнгөөс оролцох эрх гэж тодорхой заагаагүй учир Төв банк дээр

дурьдсан бие даасан байдлаа хадгалах хамгаалах бүрэн эрхтэй юм л даа. Даанч тэгэж чаддаггүй, сонгууль болгоны дараа бүлэглэлүүд өөрийн хүнээ удирдлагад тавьдаг, өнөөх нь юун гүйцэтгэх болон хууль тогтоох инстүүцийн гэхээсээ бүлэглэлийн толгойлогчдын дарамтан дор тэдэнд өрөө төлөх гэж гүрдийтлээ зүтгэдэг явдал уламжлалт заншил болжээ. Хараат бус инстүүц байж чадахгүйгээр ямар ч орны Төв банк өөрийн үндсэн үүргээ гүйцэтгэж чадахгүй. Яг л хараат бус бие даасан Шүүх байх ёстой гэдэг шиг.

Болдог бол хагас нүүр дээрхийг гишүүд, сайд нарт цээжлүүлчихмээр. Учир нь тэд Төв банкны мөнгийг өөрсдийнх нь юм, захиран зарцуулах эрх нь өөрсөдөд нь байдаг, дуртай үедээ шалгаж заавар зөвлөлгөө өгч байх ёстой, дургүй хүргээд байвал даргыг нь (Уг нь “Ерөнхийлөгч” гэдэг юм) хэзээ ч сольж болно, “Чамайг би томилсон” гэж загнах эрхтэй гэж бодоцгоодог. Бодох ч юу байхав, ерөөсөө тэгэж аашилдаг. Ийм нөхцөлд Төв банк ерөөсөө үндсэн үүргээ гүйцэтгэж чадахгүй. Ийм бол Төв банкт байх ч хэрэг үгүй, Сонгуульд ялсан бол Төв банк тухайн ялагчдын бодлогыг хэрэгжүүлэх ёстой гэдэг бол тэдний хувьд дэндүү ойлгомжтой аксиом юм. Мэргэжлийн бус тэдэнд ямар үхснийх нь бодлого байх вэ дээ, тиймээс муйхар шаардлага, тэнэг аашаа бодлого гэж үзнэ. Харсаар байтал сая төгрөг, тэрбум юанийг хооронд нь ялгах чадваргүй гишүүд гэнэт шалгагч болон очиж “15 тэрбум доллар салхинд хийсгэчихсэн байна” хэмээн чаралсаар орж ирнэ. УИХ Төв банкныг шалгах

эрхтэй байж магадгүй, гэхдээ үүнийг мэргэжлийн хүмүүсээр хийлгээд тайлан дүгнэлтийг нь сонсох учиртай. Ерөөсөө ч аль ч салбарт хийж буй УИХ болон ЗГ-ын шалгалтыг мэргэжлийн комисс хийж дүнг нь тэд сонсож байх ёстой юм л даа. Энэ улсын хамгийн дорой мэдлэг боловсролтойчууд нэг газар бөөгнөрчихөөд байгаагаа ойлгохгүй юм. Ядахнаа л валют зохицуулалтын хууль, Викселийн хууль зэргийн төв банк өөрөө санаачилж баймаар.

Төв банкныг шалгаж шаардаж бодлогыг нь шүүмжилж, сайшааж байх эзэн нь олон нийт юм. Сүүлийн үед тэргүүлэх орны Төв банкууд мэдээллийн хэрэгслэлээр бодлого болон шийдвэрээ байнга мэдээлж байх болжээ. Үүний дотор нийгмийн сүлжээгээр мэдээгээ тарааж амьд холбоо тогтоох нь хамгийн үр дүнтэй гэж үзэж байна. Төв банкууд твитэрийг их ашиглах боллоо. Фэйсбүк дээр арай цөөн. Гаргаж буй шийдвэрээ ютуб дээр видеоогоор ч цацдаг болж. Манай Төв банкны шийдвэр бодлого дандаа нууц явсаар ирсэн. Тиймээс тэндхийн шийдвэр гаргагчид валютын наймаачидтай хамтран спекуляци хийсээр ирсэн нь нууц ч юм биш.

Дэлхий даяар алдартай Германий Хроник хэвлэлийн газраас дэлхийн түүхийг зуунаар, жилээр, сараар, өдрөөр тэмдэглэдэг номнууд хийдэг. Тэндэхийн “Хорьдугаар зууны хроник - өдөр өдрөөр” хэмээх бараг төө шахам зузаан номд Монголын тухай дөрвөн газар тэмдэглэсэн байна билээ. 1910 оны (сар өдрийг нь мартаж) Оросын цэрэг Монголд нэвтрэв (Туваг хэлж буй бололтой),

1924.11.26- Монголд зөвлөлт маягийн засаг тогтов, 1991.5.20 – Монголд Төв банк байгуулагдав гэж байсан шүү. Үүнээс өмнө Монголд Төв банк байсан гэхэд хэцүү. 1925 онд “анхны” гэгдэх банк байгуулагдсан гэх авч нэг талаас өмнө нь Монголд арилжааны банк байсан, хоёрт, зөвлөлтүүдийн байгуулсан тэр банк арилжааных уу, эмиссийнх үү, үндэснийх үү, гадных уу зэрэг нь ойлгогддоггүй. Төгрөг нэртэй анхны эмисс хийсэн боловч дэвсгэрт дээр гарын үсэг зурагсад нь оросууд байдаг.

1937 онд Зөвлөлтийн цэрэг Монголд орж ирэхэд тэр жил болсон их хядлагыг газар дээр нь зохион байгуулсан Бүрэн эрхт төлөөлөгч Мироновоос Москва руу бичихдээ “Манай цэргийн ангиуд энд ирээд байрлаж төвхнөхтэй холбогдон монгол төгрөг их хэмжээгээр хэрэг болж байна. Монгол банкны нийт нөөц 7 сая төгрөг байгаа нь улс даяар таржээ. Улаанбаатарт ердөө 2 сая 300 мянган төгрөг байна. Иймээс нэн дарай 10 сая төгрөг үйлдэн нааш шилжүүлэхийг Госзнакт үүрэг болгож шинээр хэвлэсэн мөнгийг яаралтай ирүүлнэ үү” гэжээ. Хүсэлтийг яаралтай биелүүлж илгээсэн. Хонь 50 мөнгө, бүдүүн шар үхэр 10 төгрөгийн үнэтэй байснаа энэ шийдвэрийн дараа цай 10 төгрөг болсон юм. Ингэхээр Үндэсний Төв банк байсан гэхэд хэцүү.

1991 онд Бямбасүрэнгийн Засгийн газраас монгол төгрөгийн ханшийг хоёр дахин унагах 20 дугаар тогтоол гарсныг ихэд муулдаг. Монголд байрлаж байсан 100 мянган зөвлөлт цэрэг, тэдний эхнэр хүүхдийн дунд Ленинградад

хэвлэгддэг төгрөг хичнээн байсныг Монголын ганц байсан банк нь мэддэггүй байсан. Тэдний гар дээр байгаа мөнгөний ханшийг огцом унагаж байж нийт төгрөгийнхөө баримжааг олж мэдэн удалгүй шинэ эмисс хийсэн нь тухайн үедээ тун оновчтой, эдийн засгийн хувьд зайлшгүй хийх ёстой байсан арга хэмжээ юм. Тэрний дараа л үнэнгээсээ Монголд анхны үндэсний Төв банк байгуулагдсан юм шүү дээ.

Монгол банкны анхны Ерөнхийлөгч Жаргалсайхан, дараа нь Моломжамц, Үнэнбат, Чулуунбат, тэгээд богино хугацаанд бас нэг нөхөр, дараа нь Пүрэвдорж, Золжаргал, Баяртсайхан гээд дараалж байна. Үнэнийг хэлэхэд бүгдээрээ сонгуульд ялсан намын төлөөлөгчид. Яг бие даасан хараат бус бодлого баримталж ажилласан нь хэд юм бол? 1992-96 онд тогтож байсан Засгийн газрын үед инфляци 360 хувь хүрч мөнөөх 1937 оны рекордыг эвдэж байлаа. Олон Ерөнхийлөгч (мэдээж Төв банкны) Засгийн газрын хуралд суун Ерөнхий сайдаас үүрэг даалгавар аван гардаг байсан. Үүнийгээ бас зөвшилцөл гэж хөөрхөн нэрлэнэ ээ, болоогүй. Ажигласнаар Пүрэвдорж л Ерөнхий сайдын үгэнд ордоггүй байсан байх юм. Үнэнбат ердөө 6 сая долларын нөөцтэй банкныг аваад төгрөгийн ханшийг тэр даржин үед тогтоон барьж чадсан. Энэ ханш дээшээ доошоо савалгаатай боловч бараг 20 жил төвшингөө хадгалсаар ирсэн юм шүү.

Золжаргал Ерөнхийлөгчийн мөнгөний бодлого маш буруу

байсан. Үүнийг би өөрт нь ч хэлж байсан, сонин хэвлэлд ч бичиж байсан. Тэрээр нөөцийн мөнгийг барилга үйлдвэрлэл, зам тавихад хайр найргүй зарцуулж байсныгаа “нүх ухуулаад цалин өг, эргэж булуулаад бас мөнгө төл” гэсэн Кэйнсийн бодлогоор тайлбарлаж хүмүүс мөнгөтэй болбол худалдан авалт өргөжиж эдийн засаг сэргэнэ гэж мэтгэж байлаа. Гэвч улсын даржин нөөц шавхагдсан ба энэ хооронд барилгууд ч дууссан юм байхгүй балгас болж, зуун жилийн дараа ч өртгөө нөхөж чадахгүй баахан замтай боллоо. Барилга, зам бол Засгийн газрын ажил, Төв банк төгрөгөө арчилж, инфляцийг доод төвшинд барьж байх үндсэн үүрэгтэй.

Улс төр, эдийн засгийн бодлогод хаана ч алдаа дутагдал гардаг. Чөлөөт ардчилсан оронд үүнийг шүүмжилдэг болохоос шийтгэдэггүй. Гэтэл дараа нь гарч ирсэн засаг хөөрхий Золушкаг бодлогын алдаа гаргасных нь төлөө шоронд хийж шонд дүүжлэхийг шаардах болсон. Бас арай ч ингэдэггүй юмаа. Монгол банкны Ерөнхийлөгч хувьдаа мөнгө төгрөг идсэн бол тэр нь эрүүгийн хэрэг, үүнийхээ төлөө ял шийтгэл авах ёстой. Бодлогын алдаа гаргаагүй нэг ч Засгийн газар 1911 оноос тоолоод ганц ч байхгүй. Монгол банк гэгдэх манай Төв банкны хамгийн том уламжлалт алдаа бол бие даасан хараат бус ажиллагаатай байж чаддаггүй. Эзэн нь богино хугацаанд төрийн эрх мэдэл авдаг, энэ хооронд Төв банк нь эзэндээ ачийг нь хариулах гэж зүтгэдэг. Гэтэл эзэн

гэгдээд байгаачууд нь голдуу банк санхүү байтугай 35 үсгээ бүрэн тогтоосон нь эргэлзээтэй эрхэмүүд шүү дээ. Харин ч алдаатай боловч Золжаргалд өөрийн гэх бодлого байсан юм шүү. Буруу л тооцоолсон.

Засгийн газар инфляци үүсгэх сонирхолтой байдаг. Ингэснээр бага мөнгө төлөх учир цаад натур нь үүн рүү түлхэнэ. Үүнээс нь хамгаалах инстүүц бол Төв банк. Сонирхлын ийм том зөрчилтэй учраас төлөвшсөн орнуудад Төв банкны Ерөнхийлөгчийг гүйцэтгэх ба хууль тогтоох байгууллагын төлөөлөгчидтэй санаандгүй байдлаар ч биечлэн уулзахыг хуулиар хориглодог юм билээ. Манайх шиг Санхүү - Эдийн засгийн яам (нэг нь мөнгө цуглуулдаг нөгөө нь мөнгө тараадаг эсрэг тэсрэг үйлдэл), Шударга өрсөлдөөн – хэрэглэгчийн ашиг хамгаалах агентлаг (нэг нь үнэ буулгаж зах зээлд дэмпингээр монопол тогтоохын эсрэг, нөгөө нь үнийг аль болох доош татах эсрэг тэсрэг чиглэл) байгуулдаг байтугай ажиллуулдаг улс оронд Ерөнхий сайд, Төв банкны Ерөнхийлөгч хоёр сийамын ихэр гэгч шиг шадарлан өвөртөө унтах шахан хамтарч ажиллаад байгаад гайхах ч юу байхав дээ.

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайханыг огцруулах тухай асуудлыг зарим УИХ-ын гишүүн болоод сөрөг хүчнээс сүүлийн гурван жилд хэдэнтэй тавьсан ч түүний эрхэлж буй үйл ажиллагаатай нийцэхгүй байлаа. Харин УИХ-ын даргаас Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх FATF олон улсын байгууллагын хяналтад орсонтой холбогдуулж Монголбанкны Ерөнхийлөгчид хариуцлага тооцох саналыг УИХ-д тавиад байна. Гэвч үүнд хууль зүйн үндэслэлтэй эсэхэд мэргэжлийн судлаач, эдийн засагчид эсрэг байр суурийг илэрхийлж байгаа билээ.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГАД ХҮРГҮҮЛСЭН ЗАХИДАЛ

Огноо: 2019/11/03

Улсын Их Хурлын Хүндэт Даргаа,

УИХ-ын чуулганаар Монголбанкны Ерөнхийлөгчийг чөлөөлөх асуудал хэлэлцэхээр болж байгааг дөнгөж сая мэдлээ. Төрийн түшээ нар мэргэн оюун ухаандаа тунгаан үзэж гаргах шийдвэрийг миний бие хүлээн авах болно.

Улс орны эдийн засгийн амьдралын амаргүй, хүнд цаг үед Төв банкны Ерөнхийлөгчөөр 3 жил ажилласан хүний хувьд УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос оруулан хэлэлцүүлэх Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарим зүйлийг түүхэнд үлдэг хэмээн Танд бичгээр хандаж байна.

Нэг. Бидний ой тогтоомж богино байж болохгүй. 2016 онд Монгол Улс дефолтын өмнө зогсож байсан юм. Одоогоос 3 жилийн өмнө эдийн засгийн ямар хүнд байдал нүүрлэж улс орон дампуурлаа зарлахад ойрхон болоод байсныг олон хүн мартжээ. Хэрэв Монгол орны зээлжих эрхийн зэрэглэл "D" болсон тохиолдолд манай улсын хөгжил 10 жилээр ухарна гэдэг дүгнэлтийг Монголбанкны мэргэжлийн судлаачид надад гаргаж өгсөн бөгөөд УИХ, Засгийн газар дээр олон ярьж хэлэлцсэний үр дүнд дефолтоос зайлсхийх, үүний тулд ОУВС-тай хамтран хөтөлбөр хэрэгжүүлэх тухай улс төрийн шийдэл гарсан тул Засгийн газар, Монголбанк хамтран хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Хоёр. Олон улсын валютын сантай хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр тохирсон бөгөөд энэхүү хөтөлбөрийн банкны салбартай холбоотой хэсгийг Монголбанк хариуцан хэрэгжүүлж байна. Хөтөлбөр амжилттай явагдаж байна. 2017 онд Монголын бүх банкуудад Активын чанарын үнэлгээ хийгдсэн бөгөөд үнэлгээний дүнгээр өөрийн хөрөнгө дутагдалтай гарсан 7 банкинд 2018 оны 12 дугаар сарын 31-ний дотор багтаан хөрөнгө нэмэх даалгавар өгч нэгээс бусад нь Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд Монголбанкнаас өгсөн үүргийг биелүүлэв. Одоо эдгээр банкууд дээр өөрийн хөрөнгө нэмсэн эх үүсвэрт магадлан шалгах аудит хийж түүний мөрөөр авч хэрэгжүүлэх дүгнэлт гаргах ажил ид эхэлж байна.

Гурав. Аливаа орны Төв банк нь мөнгөн тэмдэгт хэвлэн гүйлгээнд оруулах онцгой эрхтэй, энэ эрхийг хэрэгжүүлэгч байгууллагыг хараа хяналтдаа оруулах оролдлого улс орон болгонд өрнөж ирсэн тул Төв банкны бие даасан, хараат бус үйл ажиллагааг хангах зарчим дэлхий даяар мөрдөгддөг.

Өнгөрсөн 3 жилийн хугацаанд банкны салбарын хууль эрх зүйн шинэчлэл Улсын Их Хурлын дэмжлэгтэйгээр хийгдэж Монголбанкны үйл ажиллагаанд хамтын удирдлагын зарчим нэвтрэв.

Монголбанкны Ерөнхийлөгч дангаар шийддэг байсан олон асуудлыг одоо Захирлуудын зөвлөл, Банкны

Хяналт шалгалтын хороо, Мөнгөний бодлогын хороо, Хяналтын зөвлөл гэсэн хуулийн хүрээнд байгуулагдсан бүтцүүд дээр хэлэлцэгдэн олонхоор шийдвэр гаргах боллоо. Монголбанкны Ерөнхийлөгчийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх нь Монголбанк хэмээх 500 орчим ажилтантай баг, хамт олны үйл ажиллагааг дүгнэх явдал тул асуудалд бодитой хандаж, шударга, үнэн зөв ажиллахыг хүсье. Төв банкны Ерөнхийлөгчийг хугацаанаас өмнө чөлөөлнө гэдэг нь Төв банкны бие даасан, хараат бус байдалд нөлөөлж буй явдал. 1990 оноос хойш Монголбанкны Ерөнхийлөгчөөр 8 хүн ажилласнаас зөвхөн нэг Ерөнхийлөгч л бүрэн эрхийн хугацаагаа дуусгажээ.

Дөрөв. Манай орны эдийн засагт дараах ахиц, нааштай өөрчлөлтүүд гарч байна.

- Эдийн засгийн өсөлт 7-8 хувьд хүрэв. Ажилгүйдэл буурлаа. Инфляци зорилтот түвшинд хадгалагдаж байна. Иргэдийн амьжиргааны үзүүлэлтүүд дээшилж эхлэв. Зээлийн хүү буурч байна.

- Монгол Улсын гадаад валютын албан нөөц сүүлийн 2 жилд 4 дахин өсөв. Энэ бол улс орны тусгаар тогтнолын санхүүгийн баталгаа тул цаашид ч нэмэгдүүлэн Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд зааснаар нэг жилийн импорттой тэнцэх хэмжээнд хүргэх учиртай. Тэгээд ч 2020-2024 онд манай улсын төлөх гадаад өр төлбөр 14.3 тэрбум ам.доллар болоод байгаа тул одоо байгаа ГВАН болох 4 тэрбум ам.долларыг хороох бус, харин арвижуулах учиртай.

- Төв банкны хуримтлагдсан алдагдал 3 их наяд төгрөгт 2016 онд хүрч үйл ажиллагаагаа явуулахад бэрхшээлтэй байсан тул сүүлийн 2 жил алдагдал бууруулах чиглэлээр тууштай ажиллан 1.5 их наядаар буурлаа.

- Монгол Улсын төлбөрийн систем шинэчлэх далайцтай том ажил өрнөж байна. Дэлхийн шилдэг түвшинд, хэний ч өмнө нүүр бардам байх Үндэсний цахим гүйлгээний систем удахгүй бэлэн болно.

Энэ мэт олон зүйлийг тоочин бичиж болно. Эдгээрт Монголбанкны идэвхтэй оролцоо, үйл ажиллагаа нөлөөлсөн гэдэг эргэлзээгүй. Үүнийг үгүйсгэвээс сүүлийн 2-3 жилд Монголын нийгэмд ажиглагдаж эхэлсэн нааштай, өнгөтэй болгоныг үгүйсгэсэн явдал болно.

Тав. Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурал нь Төрийн Мөнгөний бодлого тодорхойлно гэжээ.

Монголбанк бол Төрийн мөнгөний бодлого хэрэгжүүлнэ. Хэрэв мөнгөний бодлого алдаа зөрүүтэй байсан бол бүхнийг Монголбанкинд тохох боломжгүй. Бид Улсын Их Хурлын шийдвэр, даалгаврыг хуулийн хүрээнд даган мөрдөж биелүүлж ирсэн. Харин ОУВС-гийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн дагуу Монголбанк нь төсвийн шинжтэй үйл ажиллагаа санхүүжүүлэхгүй байх амлалт авсан бөгөөд одоо хэрэгжүүлж буй Ипотекийн хөтөлбөрийг 2020 оноос Засгийн газарт шилжүүлэхээр ажиллаж байна.

Зургаа. Монгол Улс саарал жагсаалтад орох нөхцөл байдал 2015-2016 онд өгсөн үнэлгээнээс шалтгаалан 2016-2017 онд бүрдээд байсан. Харин бид шуурхай ажиллаж, холбогдох үзүүлэлтүүдээ сайжруулж чадсанаар 2018 онд эрчимтэй хяналтад орсон юм.

2019 оны 8 сард Австралийн Канберра хотод хуралдсан Ази-Номхон далайн бүлгийн хурал 10 дугаар сард ФАТФ-ын хурлаар Монголын тайланг хэлэлцсэн бөгөөд манай олон үзүүлэлт наашилж сайжирсныг Олон улсын байгууллагаас хүлээн зөвшөөрсөн болно. Энэ асуудал нь хууль тогтоох, гүйцэтгэх засаглал, шүүх байгууллага, цагдаа, тагнуул, прокурор, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, банкууд зэрэг олон байгууллагын хамтын үйл ажиллагаанаас хамаарах бөгөөд үр дагавар нь банкны салбарт шууд илэрч, банкуудын гадаад харилцаа хязгаарлагдаж эхлэх тул Монголбанк эхнээс нь анхааран хөөцөлдөж Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба, түүний хамтын ажиллагааны зөвлөлөөр дамжуулан шаардлагатай бүх үйл ажиллагаа, хурал зөвлөгөөний зардлыг санхүүжүүлэн ажиллаж ирлээ. Харин энэхүү хүчин чармайлтыг буруугаар мушгин тайлбарлаж "Саарал жагсаалтад орох нь дан ганц Монголбанкнаас хамаарах мэтээр дүгнэх нь хэт өрөөсгөл юм.

Парисын хурлаас баталсан Монгол Улсын хэрэгжүүлэх нэмэлт ажлын төлөвлөгөөнд Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн бус мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч этгээдийн шалгах чиг үүрэг бүхий байгууллагууд, Хууль сахиулах байгууллагууд, Гадаад хэргийн яам, Гаалийн ерөнхий газрын хариуцан хийх ажил чиг үүргийг тусгасан байна.

Долоо. Одоо ханшийн талаар: 2012-2016 онд Монголбанк нийтдээ 7 тэрбум ам.долларын интервенц хийж байж төгрөг ам.долларын ханшийг 2000 төгрөгөөс доош барьж иржээ.

Үр дүнд нь Монгол улс гадаад валютын 4,3 тэрбум долларын албан нөөцөө барж дууссанаас гадна Хятадын Ардын банкинд 1,7 тэрбум ам.долларын өртэй үлдэж, гадаад өр төлбөр нэмэгдсэн байна. 2016 оны 11 дүгээр сарын 11-нд 1 ам.долларын ханш огцом өсөж 2720 төгрөг хүрсэн бөгөөд энэ үед интервенц хийх нөөцгүй шахам болж ГВАН 980 сая ам.доллар болоод байсан юм. Миний бие хэт их интервенц хийх замаар ГВАН хоослох явдлаас татгалзах бодлого явуулж ирлээ. Харин ГВАН нэмэх боломжтой бүх арга замыг эрэлхийлэн ашиглах байр суурь баримтлав. Намайг Монголбанкны Ерөнхийлөгч болохын урд 407 сая ам.доллар Оросын холбооны улс руу шилжин гарч зах зээлд валютын хомсдол үүсээд байсныг хожим нь олж мэдсэн болно. Гэтэл эдийн засагт асар их сул чөлөөтэй мөнгө эргэлдэж байсан юм. Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар 40-60 хувьд хүрээд байв. Иймд мөнгөний бодлогын хүүг нэмэгдүүлэхийн хамт макро зохистой бодлогын арга хэмжээ авч эхэлсэн нь үр дүнгээ өгсөн юм. Мөнгөний бодлогын хүү удаан хугацаанд өндөр түвшинд байх нь эдийн засгийн идэвхжилд сөрөг нөлөөлөх тул аажмаар зөөллөх бодлого явууллаа. Эдгээр бодлогын үр дүнд

өнөөдөр ам.долларын төгрөгийн ханш 2690 орчим төгрөгийн хэмжээнд тогтворжоод байна. Ер нь валютын ханш бол эдийн засгийн тэнцвэрийг олж хангах, экспортыг дэмжих, импортыг хязгаарлах, ГВАН-ийг нэмэгдүүлэх чухал хэрэгсэл бөгөөд чөлөөт зарчмаар зэх зээлд тогтох учиртай гэж үздэг.

Найм. Н.Баяртсайхан, миний бие 20 настайдаа Эрхүүгийн УАААДС төгсөн ирж Намын дээд сургуульд эдийн засгийн багш, 30 настайдаа Монгол Улсын анхдугаар Их хурлын гишүүн болсон бөгөөд улс, төрд 37 жил сэтгэл хүч чадлаа дайчлан зүтгэж ирэв. Энэ хугацаанд УИХ-ын гишүүнээр түмэн олны итгэл хүлээн 4 удаа сонгогдож, хэд хэдэн байнгын хорооны даргаар ажиллаж, Монгол Улсын Сангийн сайд, Үйлдвэр-Худалдааны сайдын үүрэг гүйцэтгэгч, Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилогдон ажиллалаа. Надад итгэл, хариуцлага хүлээлгэн төр улсад зүтгүүлсэн Монголын ард түмэндээ гүнээ ёсолж хөгжил дэвшил, амгалан тайван амьдралыг хүсэн ерөөе. Сайн сайхан үйлс дэлгэрэн бадарч явах болтугай. Улсын Их Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, ЭДИЙН ЗАСГИЙН
УХААНЫ ДОКТОР, ПРОФЕССОР Н.БАЯРТСАЙХАН

УИХ-ААС МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИД ТАВИХ ХАРИУЦЛАГЫН АСУУДАЛД ЭДИЙН ЗАСАГЧДЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛД ӨГСӨН БАЙР СУУРЬ

М.Энхсайхан: Нэг, хоёр хүн дээр тооцоо бодоод асуудал шийдэгдэхгүй

Монгол Улсын Ерөнхий сайд асан

Сүрбадруулж, өөрөө өөрсдийгөө айлгахдаа гол нь биш. Өөрсдөдөө зөв дүгнэлт хийж, бодлогын аажим алхмуудаар асуудлыг засах нь чухал гэж хэлмээр байна. Нэг, хоёр хүн дээр тооцоо бодоод асуудал явахгүй л дээ. Ялангуяа сүүлийн үед хоёр хүн дээр тооцоо бодно гээд байна шүү дээ. Жишээлбэл, Монголбанкны Ерөнхийлөгч дээр тооцоо бодно гэдэг бол маш гүнзгий үндэслэлтэй байх ёстой. Би санаа зовж байгаа. Яагаад гэвэл Монголбанк Засгийн газар, улс төрчдөөс хамааралгүйгээр бие даасан үйл ажиллагаа явуулах ёстой. Тэгж бодож, бид анх Төв банкны тухай хууль, банкны тухай хуулиа хийж байсан. Мөнгөний бодлого төсвийн бодлоготой холилдож болохгүй. Цаасан мөнгийг хамаагүй хэвлээд байж болохгүй. Тийм дарамт, шахалт Монголбанкинд урд өмнө ирдэг л байсан. Одоо популизм дэлгэрсэн үед тийм шахалт бүр ч их ирж байгаа. Одоо тэгээд саарал жагсаалт гэдгээр далимдуулаад, Монголбанкны Ерөнхийлөгчийг өөрчиллөө гэхэд дараагийн хүн нь ирээд, ямар бодлого явуулах вэ, бие даасан бодлогоо хэрэгжүүлж чадах уу гэдэг дээр эргэлзээ төрүүлнэ. Тэр эргэлзээ санхүүгийн тогтолцоог эрүүл бус байдалд улам оруулах аюул байгаад байна. Би сайн, муу гэж хүний тухай ярьж байгаа юм биш. Дараа нь юу хийх гэж байна вэ гэдгээ харахгүй бол, биднийг саарлаас бүр хар жагсаалт руу чирэх нөхцөл болчих вий дээ гэж болгоомжилж байна.

Ж.Дэлгэрсайхан: Засгийн газар дотор байгаа буруутнуудыг шийтгэх чадамж УИХ-д алга

СЭЗИС-ийн багш, эдийн засагч

Төв банкны бие даасан байдлыг хангах асуудалд дэлхийн нийтээр л анхаарч байна. Гадаадын орнуудад хараат бус байдлыг хангахын төлөө маш сайн ажилладаг. Манайх уг нь хуультай. Төв банк хараат бус байх ёстой. Ерөнхийлөгч нь зургаан жилээр ажиллана гээд хуульд заагаад өгчихсөн. Гэтэл Монголбанкны Ерөнхийлөгчийг ийм ойр ойрхон сольдог нь улс төрийн шинж чанартай л гэж харж байна. Төв банк сүүлийн үед хамтын шийдвэр гаргадаг болсон. Засаглалын хувьд сайжирсан. Эрх зүйн орчин ч маш сайжирсан байна. Миний бодлоор Монголбанк харьцангуй академик, шинжлэх ухаанд суурилсан, судалгаатай шийдвэр гаргадаг. Тэр утгаараа Монголбанк үндсэн зорилгынхоо төлөө ажилладаг. Ажиллаж ч яваа. Байнгын хорооны хурлын үеэр Монголбанкны Ерөнхийлөгчийг буруутгаж байгаа үндэслэлүүдийг сонссон биз дээ. Их өнгөцхөн, төв банкны хийсэн ажил таалагдаагүй л гэж яриад байгаа юм. Байнгын хорооны гишүүдээс “Яг юу нь таалагдаагүй юм” гэж асуувал тоймтой хариулт олж сонсохгүй л байх.

Учир нь Монголбанк Засгийн газрын хэт үрэлгэн бодлогын эсрэг эрсдэлээс хамгаалах бодлогоо л барьж байгаа. Эдийн засагт болзошгүй эрсдэлийг хязгаарлахын тулд ажилласан. Ажлаа ч сайн хийж байгаа гэж би боддог. Монголбанкны Ерөнхийлөгчийг огцруулах шалтгаанаа ФАТФ-тай холбож байгаа нь ч бас

эргэлзээтэй. Үүнийг улс төрийн шалтгаантай холбож ойлгохоос өөр ямар ч арга байхгүй. Учир нь ФАТФ-ын бидний биелүүлээгүй гэж үзээд өгсөн зөвлөгөөнд Төв банк, санхүүгийн зохицуулах хороотой холбоотой нэг ч өгүүлбэр байхгүй. Улс орны хэмжээний тогтолцоо чинь ажиллахгүй байна. Гааль, хуулийн байгууллага нь хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж чадахгүй. Шалгаж, шийтгэж чадахгүй байгаа авлига, хээл хахууль, мөнгө угаахтай холбоотой асуудлаа шийдэж, сайн ажилла л гэсэн.

Улс төрийн хүрээнд энэ асуудлаа шийдэх боломжгүйгээс болоод тодорхой хүнд хариуцлага тооцсон гэж харуулахын тулд Монголбанк, СЗХ руу дайраад байна. Засгийн газар дотор байгаа буруутнуудыг шийтгэх чадамж УИХ-д ч, УИХ-ын даргад ч байхгүй байх шиг. Буруутныг олъё гэж бодвол Засгийн газар, хууль хяналтын байгууллагад байна. Гэхдээ бид энэ асуудлыг залруулахын тулд эрчимтэй ажиллах ёстой болохоос хэн нэгнийг буруутгаж, уснаас хуурай гарахаар хамаг цагаа зарцуулж байгаа нь тийм ч сайн зүйл биш.

Б.Лакшми: “Саарал жагсаалт” Монголбанк, СЗХ гэхээсээ илүү Монголыг хамарсан том асуудал

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн гүйцэтгэх захирал

Монголбанкны Ерөнхийлөгчийг огцруулах гэж байгаа нь тийм ч оновчтой шийдэл биш. Энэ байгууллага улс төрөөс хараат бус байх нь хамгийн чухал. “Саарал жагсаалт”-д орлоо гэсэн мэдээлэл гарахтай зэрэгцээд

өөрсдийнхөө нөхцөл байдалд дүгнэлт хийхгүйгээр шууд буруутан хайж эхэлсэн. “Саарал жагсаалт”-д орсон нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны гэхээсээ илүүтэй бүхэл бүтэн системийн асуудал. Санхүүгийн салбарыг хамарсан ч асуудал биш. Монгол Улсыг хамарсан том асуудал юм. Ийм том асуудалд ганц хоёрхон хүнд хариуцлага тохоод өнгөрч болохгүй. “Саарал жагсаалт”-д орсонтой холбоотойгоор бид дүгнэлтээ хийгээд, цаашид ямар алхам хийвэл үүнээс гарах боломжтой вэ гэдгээ ярих ёстой. Цаашид яах тухайгаа огт яриагүй байж хариуцлага тооцох талаар ярьж байгаа нь өрөөсгөл. Манайд нэг том асуудал байдаг. Шинэ хүн гарч ирэхээрээ л өмнөх хүнийхээ хэрэгжүүлж байсан бодлогыг үргэлжлүүлэхгүй, өөрчлөөд явчихдаг. Монголбанк сүүлийн хэдэн жил эдийн засгаа дэмжсэн, зөв бодлого явуулж байсан. Энэ талаар бүхий л эдийн засагчид ярьж, хүлээн зөвшөөрдөг. Тогтвортой л үйл ажиллагаа явуулах нь чухал байна.

Г.Ганзориг: Хаа хамаагүй хүн рүү чихэж, асуудлаа шийдсэн дүр үзүүлж байна

Эдийн засагч

“Саарал жагсаалт”-д орсонтой холбоотойгоор шийдвэр гаргаж байх шиг байна. “Саарал жагсаалт” гэдэг Монгол Улсад орж ирэх валютын урсгалыг тодорхойлдог зүйл огт биш. Монгол Улсад орж ирэх валютын урсгал их байх уу, бага байх уу гэдгийг тодорхойлдог зүйл нь зээлжих зэрэглэл. Засгийн газар зээлжих зэрэглэлээ сайжруулах талаар нэг ч арга хэмжээ авахгүй мөртлөө “Саарал жагсаалт” гээчийг гаргаж ирээд, валютын урсгал

татраад, улс сүйрэх гэж байгаа юм шиг яриад, хаа хамаагүй хүн рүү чихэж, асуудлыг шийдсэн дүр үзүүлж байна. Монголд ажил хийж байгаа хүнийг халах, буулгах тухай их ярьдаг. Орлох хүн нь хэн байх талаар огт ярьдаггүй. Дараагийн хүн гарч ирээд юу хийхээ бас ярьдаггүй. Зүйрлэх юм бол, ганц хоол хийж байгаа хүнээ хөөж явуулах гээд байдаг. Хэн дараа нь, ямар хоол хийх юм, тэр нь ерөөсөө тодорхойгүй. Үүнтэй л ойролцоо үйл явдал болох гээд байна.

Г.Бумчимэг: Асуудлаа шийдэх биш буруутныг хайхад л төвлөрөөд байна

Монголын эдийн засгийн шинжилгээ, судалгааны төвийн гүйцэтгэх захирал

Төв банк хараат бус байх ёстой. Гэтэл төв банк үүссэнээс хойшхи түүхийг харахад, УИХ Монголбанкны Ерөнхийлөгчийг хугацаа нь дуусахаас өмнө огцруулдаг жишиг тогтчихоод байна. Энэ маш буруу. Үндсэн чиглэлээ хэлэлцүүлээд, УИХ-аар батлуулчихдаг. Тийм байтал удирдлагыг нь сольж байгааг харахад, хараат бус байна гэж хэлэхэд тун хүндрэлтэй. Мөнгө угаах, терроризмтэй тэмцэх асуудлыг бид ярих ёстой. Манайхан аливаа асуудлыг шийдэхдээ юу хийхээ төвлөрдөггүй. Хэн нэг буруутныг хайхад төвлөрөөд байна. Анзаараад байхад ФАТФ-ын өгсөн үүрэг даалгаврыг яаж биелүүлэх вэ гэж төвлөрч ярилцахаасаа илүү хэнд хариуцлага тооцох вэ гэдэгт илүү анхаарал хандуулж байгаа нь харамсалтай. Төв банкны Ерөнхийлөгчийг ингэж хурдан сольж боломгүй байна. Мөнгөнийн бодлогын зөвлөлийн гишүүдийг ч гэсэн маш хурдан сольдог. Ийм баймааргүй байна.

Г.Рагчаасүрэн: Төв банкны Ерөнхийлөгчийг хугацаанаас нь өмнө чөлөөлж байгаа нь монгол төр өөрөө сул байгаагийн шинж

Эдийн засагч, судлаач

Төв банкны Ерөнхийлөгч бүрэн эрхийг хугацаагаа дуустал 6 жилийн хугацаанд ажиллаж чадахгүй байна. Гэтэл үнэхээр муу ажиллаад байна уу гээд харвал үндсэн зорилтууд бүгд л хангагдаж байна. Инфляцийг тогтворжуулсан, ханш тогтвортой, эдийн засгийн өсөлт хангагдсан гээд. Гадаад эдийн засгийн сайн, эерэг нөлөөллүүд ч байсан л байх. Харин өнөөдөр “саарал жагсаалт” гэдэг зүйлд үндэслэж Монголбанкны Ерөнхийлөгчийг огцруулъя гэж байгаа бол “саарал жагсаалт” гэдэг зүйлийн уг, үндэс хаана байна вэ, яг юунаас болж энэ асуудал үүсэв гэдгийг маш сайн тодотгох ёстой. Явж явж, бидний яриад байсан Ил тод байдлын тухай хууль юм биш үү. Тэгвэл Ил тод байдлын хуулийг УИХ баталсан. Тухайн үеийн УИХ-аас гарсан шийдвэр хэрэгжээд явж байхад одоогийн төв банкны хүмүүс яагаад хариуцлага хүлээдэг юм. Одоо ажиллаж байгаа Санхүүгийн зохицуулах хорооны дарга яахаараа тэрний төлөө өргөдлөө өгөх ёстой юм. Гээд ярихаар, эцсийн дүндээ УИХ, төр маань өөрөө ажлаа хийж чадаж байна уу, үгүй юу гэдэг л асуудал байна. Тэгэхээр энэ нь төр өөрөө их сул байгаагийн л шинж юм.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАЯРТСАЙХАНЫ ХЭЛСЭН ҮГ, ЯРИЛЦЛАГА, НИЙТЛЭЛ, СУДАЛГААНЫ АЖЛУУД (2016-2019 ОН)

Тэрээр эдгээр ярилцлага, нийтлэл, судалгааны бүтээлүүддээ эдийн засгийг тогтворжуулах, эдийн засгийг мөнгөний бодлогоор дэмжих, гадаад орчны нэмэгдэж буй эрсдэлээс хэрхэн сэргийлэх тухай, үүн дотроо банкны салбарын тулгамдаж буй асуудал, түүнийг шинэчлэн хөгжүүлэх, төв банкны хараат бус байдлыг бэхжүүлэх, санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, төлбөр тооцооны системийн үр ашигтай, аюулгүй байдлыг бэхжүүлэх зэрэг хөгжил дэвшилд хүрэх чухал санаануудыг дэвшүүлжээ.

2016-2017 он

Сонин, сэтгүүл, телевизэд өгсөн ярилцлага

- Монгол оронд хөгжлийн сайхан ирээдүй бий ... /Эх сурвалж. Өдрийн сонин - №189 2016.08.18/
- Бидний үнэт зүйл бол Монгол орон, Монгол хүн, Монголбанк /Эх сурвалж: “Монголбанкны мэдээлэл” товхимол №1 2016.11.01/
- Амаргүй сорилт, шалгалтыг бид давж гарна /Эх сурвалж: Зууны мэдээ №248 2016.12.05/
- Төрийн мөнгөний бодлого эдийн засгийн хүндрэлийг даван туулахад бүхэлдээ чиглэнэ /Эх сурвалж: Зууны мэдээ №248 – 2016.12.12/
- Дэлхийн аль ч улсад баримталдаг том зарчим бол Төв банкны бие даасан байдал юм /Эх сурвалж: Өдрийн сонин №289 2016.12.14/
- Иргэдийг орон сууцжуулах бодлого үргэлжлэн хэрэгжиж байна ... /Эх сурвалж. Үндэсний шуудан №244 2016.12.15/
- 2018 оны хоёрдугаар хагас гэхэд тогтвортой хөгжлийн замд баттай гарсан байхын төлөө зүтгэж байна /Эх сурвалж: “Open door” сонин №48. 2016.12.16/
- Монгол Улсын эдийн засгийн төлөв эерэг, сайн байгаа /Эх сурвалж: Өдрийн сонин №02 2017.01.04/
- 2018 оны хоёрдугаар хагас гэхэд тогтвортой хөгжлийн замд баттай гарсан байхын төлөө зүтгэж байна /Эх сурвалж: “Open door” сонин №48. 2016.12.16/
- Төв банкны хариуцлагыг өндөржүүлнэ ... /Эх сурвалж: Зууны мэдээ №006. 2017.01.10/
- Актив удирдлагын компанитай болно /Эх сурвалж: Зууны мэдээ №06 2017.01.10/
- Төв банкны хариуцлагыг өндөржүүлнэ ... /Эх сурвалж: Зууны мэдээ №006. 2017.01.10/
- Цаашид гадаад валютын ханштай холбоотой эрсдэл буурсан нөхцөлд мөнгөний бодлогыг зөөлрүүлэх бололцоо бүрдэнэ ... /Эх сурвалж: “Зууны мэдээ” №122 2017.05.31/
- Эдийн засгийн өсөлт хөгжил, тогтвортой байдалд чиглэсэн бодлогын шийдвэр гаргахаар ажиллаж байна /Эх сурвалж: Өдрийн сонин №131. 2017.06.12/
- Чанаргүй активуудыг шуурхай шийдвэрлэснээр эдийн засгийн хүндрэлийг даван туулж чадна /Эх сурвалж: “Banking in Mongolia” сэтгүүл. №4, 2017.01/
- Би төв банкны бие даасан байдлыг хамгаална. /Эх сурвалж: 25 дугаар суваг тв, “Ам нээвэл” зочны ярилцлагын цаг/
- Эдийн засагт бий болсон өөрчлөлтүүдээ бататгах нь чухал байна /Эх сурвалж: “Улс төрийн тойм” сонин №7. 2017.11.13/
- Макро эдийн засагт бодит эерэг өөрчлөлтүүд эхнээсээ мэдрэгдэж эхэллээ /Эх сурвалж: Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах Үндсэн чиглэлийг хэлэлцэн батлах

үед Монголбанкны Ерөнхийлөгчийн УИХ-ын чуулганд хийсэн мэдээлэл. 2017.09.29/

- 2018 он бол эдийн засгийн реформуудаа хийх цаг /Эх сурвалж: Өнөөдөр сонин №267. 2017.11.07/
- Эдийн засгийн сэргэлт банк, санхүүгийн реформоос хамаарна /Эх сурвалж: Өдрийн сонин №266, 2017.12.14/

Илтгэл, судалгааны өгүүлэл, нийтлэл

- А.П.Суходолов, Н.Баяртсайхан, О.Юу.Оношко. Банковская система Монголии: трансформация в условиях глобализации /Эх сурвалж: Bulletin fo Baikal State university, 2016, vol. 26, no. 6, pp. 855-867/
- Н.Баяртсайхан: Туулсан 25 жил: сургамж сорилт /Эх сурвалж: "Мөнгө, санхүү баялаг" сэтгүүл. 2017.№1/
- Н.Баяртсайхан, Д.Ган-Очир. Эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг бий болгох бодлогын асуудалд /Эх сурвалж: "Мөнгө, санхүү баялаг" сэтгүүл. 2017.№2/
- Доклад на международной научно-практической конференции "Евразийское сотрудничество: гуманитарные аспекты" 2017.09.14
- Н.Баяртсайхан: Монгол Улсын банкны салбарын хууль эрх зүйн орчин, хөгжил шинэчлэл /Эх сурвалж: "Мөнгө, санхүү, баялаг" сэтгүүл. 2017. №3/
- Даяаршлын ерөнц дэх Монгол Улс /Эх сурвалж: Н.Баяртсайхан: Хоршоолол Монгол оронд: Одоо, ирээдүй - 2014/
- Тогтворжилт, өсөлтийн зүгт /Эх сурвалж: "Mongolian Economy" сэтгүүл 2017/

2018 он

Судалгааны өгүүлэл, нийтлэл, илтгэл

- "Монголбанкны мөнгөний бодлогын түүх" /Мөнгө, санхүү, баялаг" сэтгүүл 2018.№10/
- "Тогтворжилт, өсөлтийн зүгт" /Мөнгө, санхүү, баялаг" сэтгүүл 2018.№4/
- Зээлийн хүүг бууруулах стратеги /Эх сурвалж: "Мөнгө, санхүү, баялаг" сэтгүүл 2018.05/
- Монголын эдийн засгийн чуулга уулзалт: Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалтад тавьсан илтгэл /"Мөнгө, санхүү, баялаг" сэтгүүл 2018. №5/
- "Их өр"-ийн асуудлыг шийдвэрлэсэн нь /Эх сурвалж: Мөнгө, санхүү, баялаг" сэтгүүл, 2018.№09/

Өдөр тутмын сонин, хэвлэлд өгсөн ярилцлага

- Эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийн тулгуур нь санхүүгийн хэрэглэгч /Эх сурвалж "Зууны мэдээ" №014/5721 - 2018.01.18/
- "Тогтвортой, хүртээмжтэй өсөлт хэрэгтэй" – /Эх сурвалж: "Өдрийн сонин" №27, 2018.02.20/
- Банкны хяналт шалгалт, зохицуулалтыг олон улсын стандарт, жишгийн дагуу хийдэг болно /Эх сурвалж: "Үндэсний шуудан" №33, 2018.02.20/
- Томоохон үйлдвэр, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж олон улсын тавцанд гаргаж ирэх нь эдийн засгийн бодлогын суурь зарчим /Эх сурвалж: "Өглөөний сонин" №31, 2018.02.21/
- Банкны салбарын төлбөрийн чадварыг бүхэлдээ тогтвортой гэж дүгнэсэн /Эх сурвалж: "Засгийн газрын мэдээ" - №041, 2018.02.26/

- Монголбанк хуримтлагдсан алдагдлаа буурууллаа /Эх сурвалж: “Өнөөдөр” сонин, №62, 2018.04.02/
- Мөнгөний бодлого бодит эдийн засгийн сэргэлтийг дэмжинэ /Эх сурвалж: “Өнөөдөр” сонин. 2018.04.27/
- Төв банк алс ирээдүйг харсан бодлого явуулна /Эх сурвалж: “Өнөөдөр” сонин №082. 2018.06.11/
- Эдийн засгийн сэргэлт бий болоод удаагүй байгааг мартаж болохгүй /Эх сурвалж: “Өнөөдөр” сонин. №158, 2018.09.07/
- Эрсдэлээс холдож чадсан /Эх сурвалж: “Монголын үнэн” №158. 2018.08.22/
- Эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, хүртээмжтэй болгох үүднээс хийх ажил их байна /Эх сурвалж: “Өдрийн сонин” №178, 2018.09.07/
- Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлийн талаар /Эх сурвалж: Төрөөмс Мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах Үндсэн чиглэлийн төслийг УИХ-д өргөн барихад Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайханы өгсөн мэдээлэл – 2018.09.25/
- Ам.долларын ханшид нөлөөлж буй хүчин зүйлс /Эх сурвалж: “Үндэсний шуудан” 2018.10.11/
- Сорилтын үед эдийн засгийн тэнцвэр чухал /Эх сурвалж: Өдрийн сонин, №119. 2018.10.08/

2019 он

Нийтлэл, илтгэл

1. Монголбанкнаас хэрэгжүүлсэн бодлого үр дүн, цаашдын сорилт

Эх сурвалж: Н.Баяртсайхан “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2019, №14

2. Эдийн засгийн сэргэлт, түүний өрхийн амжиргаанд үзүүлж буй нөлөө

Эх сурвалж: Н.Баяртсайхан “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2019, №15

3. Мөнгөний бодлого: Тулгамдсан асуудлууд

Эх сурвалж: Н.Баяртсайхан “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2019, №16

Өдөр тутмын сонин хэвлэлд өгсөн ярилцлага

2019 он эрүүл чийрэг банкны жил болно Эх сурвалж: “Засгийн газрын мэдээ” №014/1066 2019.01.23

2019 онд эдийн засгийн сэргэлт үргэлжилнэ Эх сурвалж: “Зууны мэдээ” №40/6007 2019.02.27

Эдийн засагт гарсан нааштай үр дүнг улам батжуулж, тогтворжуулахыг дэмжинэ Эх сурвалж: “Өнөөдөр сонин” №055/6600 2019.03.20

Хийх ажил их, тулгарч буй сорилтууд том Эх сурвалж: “Өдрийн сонин” №124/6225 2019.06.13

Төлбөрийн систем дэлхийн шилдэг түвшинд хүрнэ Эх сурвалж: “Өдрийн сонин” №166/6267 2019.08.15

Мөнгөний бодлого, банкны хяналт зохицуулалт нь дунд хугацааны тогтвортой байдлын дархлааг нэмэгдүүлэхэд чиглэнэ Эх сурвалж: “Өдрийн сонин” №199/6300 2019.09.30

Инфляцийн дарамтгүй өсөлтийг мөнгөний бодлогоор дэмжинэ Эх сурвалж: “Форбс” сэтгүүл 2019.10.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙГ ХАМТДАА ТАСЛАН ЗОГСООЁ !



Сэжигтэй, эх үүсвэр нь тодорхойгүй мөнгө ашиглаж байгаа болон мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүдийн талаарх мэдээллийг Цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ үү.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ХЭЛТЭС
Утас: 51-265794, 51-265734

Мөнгө угаах нь хууль бус орлогыг хууль ёсны юм шиг харуулахыг зорьдог

Илт хууль бусаар олсон хөрөнгийг мэдсээр байж олж авсан, хувиргасан, шилжүүлсэн, эсхүл түүнийг хууль ёсны байдалтай болгохын тулд эх үүсвэрийг халхавчилсан, нуун далдалсан, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн, бодит шинж чанар, хэлбэр, байршлыг өөрчилснийг мөнгө угаах гэнэ.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДВОЛ ХУУЛИЙН ДАГУУ ДАРААХ АРГА ХЭМЖЭЭ АВНА



СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Иргэн Та мөнгө угаах гэмт хэргийг санаатайгаар үйлдээгүй ч дараах байдлаар холбогдож болзошгүй:

1. Бусдад өөрийн банкны данс болон төлбөрийн картыг ашиглуулах.
2. Хэн нэгний гуйлтаар эх үүсвэр нь тодорхойгүй хөрөнгө, мөнгийг шилжүүлэх, хүлээн авах.

◆ Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл анги. Мөнгө угаах гэмт хэрэг
1. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

◆ 2. Энэ гэмт хэргийг:
2.1 энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж;
2.2 байнга тогтвортой үйлдэж;
2.3 албан тушаалтан албан чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
4. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.



www.police.gov.mn



www.mongolbank.mn



www.sankhuugiinbolovsrol.mn



